



UNITED NATIONS
MONGOLIA



МОНГОЛ УЛС ДАХЬ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ҮР ДҮНГИЙН

ТАЙЛАН

2017-2018



2017-2021 НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ



**МОНГОЛ УЛС ДАХЬ
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН
АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2017-2018 он

(2017-2021) НҮБ-ын
Хөгжлийн тусламжийн хүрээ

© НҮБ-ын СЗАА 2019
Бүх эрх хамгаалагдсан
Хавтасны зургийг: ©НҮБ ХХААБ

АГУУЛГА

Тайлангийн хураангуй	3
Хөтөлбөрийн үр дүн	6
ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 1: Хүртээмжтэй өсөлт, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих;	10
Зорилго 1.1 ТХЗ-той уялдуулсан хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, стратеги, төлөвлөгөөг боловсруулах; ингэхдээ ядуурлыг бууруулах, хүртээмжтэй өсөлт, эдийн засгийг төрөлжүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд эрсдлийг даван туулахад бэлтгэлтэй байх нөхцөлийг бүрдүүлэх зэргийг тэргүүлэх чиглэлээ болгох;	14
Зорилго 1.2 Зохистой ажлын байр, ур чадварыг бий болгох, цэвэр технологийг нэвтрүүлэх, байгаль орчны доройтол, байгаль орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх, ядуурлыг бууруулах зэрэгт чиглэсэн ногоон эдийн засгийн үндэсний стратегийг боловсруулж Монголын онцлогт тохирсон, ард иргэдийн оролцоонд тулгуурласан уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох, түүний нөлөөллийг бууруулах арга хандлагыг нэвтрүүлэх;	17
Зорилго 1.3 Хөдөө орон нутгийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг тэтгэдэг экосистемийн үйлчилгээг хамгаалах;	20
Зорилго 1.4 Нутгийн иргэдийн гамшгийн эрсдлийг даван туулах чадварыг сайжруулах	22
ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 2: Нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш хүртээмжтэй нийгмийн үйлчилгээг бий болгох;	24
Зорилго 2.1 Технологийн шийдэл, ус, ариун цэврийн байгууламжийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх замаар илүү таатай орчин бүрдсэн, мэдээлэл судалгаатай, нийгмийн ухамсараар дэмжигдсэн Ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сонгогдсон хотын захын хороолол болон сумдад сайжруулах;	28
Зорилго 2.2 Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхийн тулд хот суурин, хотын захын хороолол болон хөдөө орон нутгийн ядуу, эмзэг хүн амын эрүүл мэндийг сайжруулах; эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээнд хүн бүр тэгш хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх; нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргахад үндэснийхээ байгууллагуудтай хамтран ажиллахыг дэмжих;	30
Зорилго 2.3 Илүү чанартай суурь боловсролыг дэмжиж, Хүүхдийг бага наснаас нь хөгжүүлэх, улмаар насан турш боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хотын захын хорооллын сонгогдсон хэсгүүд, зарим сумдад хэрэгжүүлэх;	32
Зорилго 2.4 Нийт хүн амыг, ялангуяа, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг ТҮЛХҮҮ хамруулсан үр ашигтай, үр нөлөөтэй нийгмийн хамгааллын тогтолцоог нэвтрүүлэх,	34
Зорилго 2.5 Хүнс болон хоол тэжээлийн аюулгүй байдлыг бэхжүүлэх (эрүүл хүнс/тэжээлийн орчинг бүрдүүлэх, хоол тэжээлийн дутлын эрсдлийг эрс бууруулах, хүнс, хоол тэжээлийн тандан судалгаа, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх).	36
ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 3: Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлэх	38
Зорилго 3.1 Хүний эрхийг хамгаалах, ялангуяа, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах зорилгоор олон улсын стандартад нийцүүлэн хууль эрх зүйн шинэчлэл хийж хяналтын тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх замаар хууль эрх зүйн хамгааллын механизмыг сайжруулах,	41

Зорилго 3.2	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд, залуучуудын (34 хүртэлх насны) төлөөллийг нэмэгдүүлэх, тухайлбал, Монгол Улсын Их хурал, яамдын сайд, төрийн нарийн бичгийн дарга, аймгийн засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгчдийн түвшинд;	43
Зорилго 3.3	Залуучуудын холбоо,байгууллагуудыг бэхжүүлэх, тэдний санаа бодлоо эрх тэгш түншийн хувьд чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих.	45
МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА		48
НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА		49
ХАВСРАЛТ: Нийт төсвийн хүрээ		50

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) нь 1963 оноос эхлэн Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ. Үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилгодоо хүрэх, тогтвортой, тэгш, хүртээмжтэй хөгжлийг хангахад чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааг НҮБ-аас дэмжин ажиллаж ирсэн. Монгол Улс 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаа хэрэгжүүлэх, Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг бодит ажил болгох их үйлсэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-ын системийн байгууллагууд олон чиглэлээр хамтран ажиллаж байна. Эдгээр чиглэл нь байгаль орчныг хамгаалах, ардчилсан засаглалыг бий болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах, эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, зохистой ажлын байрыг дэмжих, эрүүл мэнд, боловсрол, ус, ариун цэврийн байгууламж зэрэг бүх нийтийн чанартай үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон асуудлыг хамарч байна.

Эдүгээ НҮБ-ын системийн 15 байгууллага Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллах 2017-2021 онд хэрэгжүүлэх НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (ХТХ)-г баталсан билээ. Энэхүү Хөгжлийн тусламжийн хүрээ нь тус оронд НҮБ-ын системийн байгууллагуудаас 2017-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь үндэслэл болно. Түүнчлэн жил бүр НҮБ болон Монгол Улсын Засгийн газар хамтран энэхүү ХТХ-ний хэрэгжилт, ахиц дэвшилд үнэлгээ өгч дараа дараагийн жилүүдэд тавих тэргүүлэх зорилтуудаа тодорхойлж хамтран ажиллах юм.

2017-2021 оны Хөгжлийн тусламжийн хүрээ (ХТХ)-г Монгол Улсад хэрэгжүүлж эхэлсэн эхний хоёр жилийн хугацаанд буюу 2017, 2018 онуудад НҮБ-аас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гол үр дүнг энэхүү тайлангаар танилцуулж байна.

Тайлангийн хугацаанд НҮБ-ын системийн байгууллагууд нийт 61.1 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилтийг босгосон бөгөөд үүнээс 43.23 сая ам.долларын хөрөнгийг 49 хэрэгжүүлэгч түншүүдтэйгээ (IP) хамтран 18 аймаг, нийслэл хотод хэрэгжүүлж байгаа 82 төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. Эдгээр үйл ажиллагаа нь Тогтвортой хөгжлийн нийт 17 зорилгоос 16 зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг дэмжихэд зарцуулагдсан бөгөөд үүний талаас илүү хувь нь буюу 23 сая ам.долларын хөрөнгийг ТХЗ 2 – Өлсгөлөнг эцэслэх, ТХЗ 3 - Эрүүл мэндийг дэмжих, ТХЗ 5 - Жендэрийн эрх тэгш



©ДЭМБ

байдлыг хангах, ТХЗ 15 – Хуурай газрын эко системийг хамгаалах, болон ТХЗ 16 - Энхтайван, Шударга ёсыг цогцлоох зэрэг Тогтвортой хөгжлийн таван зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

НҮБ нь ТХЗ-ыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, институцийн бүтэцтэй уялдуулах системийн цогц хандлагыг баримталж байна. ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл явц, зарчмыг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 (ТХҮБ) -ын зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй хэрхэн уялдуулж нутагшуулах талаар Монгол Улсын Засгийн газар болон холбогдох талуудад зөвлөн ажиллаж байна. 2017 оны 11-р сард Монгол Улсад ажилласан Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар бодлогын зөвлөгөө өгөх НҮБ болон АХБ-ны хамтарсан Ажлын хэсгээс тус улсын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцын уялдаа холбоо, зохицуулалтын механизмыг бэхжүүлэх; ТХЗ болон ТХҮБ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн санхүүжилтийг уялдуулах; үйл явцыг үнэн бодитойгоор үнэлэх, бодлогын хэрэгжилт, хэрэгцээг тодорхойлох хяналт шинжилгээ, үнэлгээний хүчирхэг, орчин үеийн, нэгдсэн тогтолцоог бий болгох зэрэг нь тус улсын хөгжилд тун шаардлагатай байгаа талаарх зөвлөмжийг өгсөн болно. Эдгээр зөвлөмжийн мөрөөр НҮБ-ын системийн байгууллагууд нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн үйл явцыг тогтмол хянаж байх ТХЗ-ын мэдээллийн системийг (SDGs dashboard) байгуулахад нь Үндэсний Статистикийн хороонд техникийн туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-тай нягт хамтран ажиллаж байгаагийн зэрэгцээ зарим төсөлд хамтран санхүүжүүлэгчээр оролцох явдал нь нэмэгдэж байна.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд л гэхэд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газраас 2.1 сая орчим ам.долларын хөрөнгө оруулсан байна. Хамтын ажиллагааны олон сайн амжилтын нэг бол Монгол Улсын Засгийн газраас үзүүлсэн хөрөнгө санхүү болон хамтарсан санхүүжилтийн үр дүнд Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (ДГХБО-LLDC)-ын Олон улсын судалгааны төв (ОУСТ-ИТТ)-ийг Монгол Улсад 2018 онд байгуулагдсан явдал юм.

Монгол Улс нь 2018 оны 7-р сард Гамшгийн эрсдлийг бууруулах асуудлаарх Азийн орнуудын сайд нарын бага хурлыг НҮБ-ын Гамшгийн эрсдлийг бууруулах газар (UNDRR) -тай хамтран зохион байгууллаа. Энэхүү бага хурал нь засгийн газар болон оролцогч талуудад дэлхийн хамгийн ихээр гамшигт нэрвэгдсэн бүс нутгийн нэг болох Ази, Номхон далайн бүс нутагт Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарч буй ахиц дэвшлийг үнэлэх, цаашдын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох хамтарсан хэлэлцүүлгийн чухал үйл ажиллагаа болсон. Энэхүү бага хурлаар Сендайн үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг гол зорилт болох 2020 он гэхэд улс орнууд гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний болон орон нутгийн стратеги боловсруулах талаар улс орнууд идэвхтэй алхам хийхийг уриалсан юм.

НҮБ нь байгаль орчны салбарт техникийн болон зөвлөх үйлчилгээний тусламж үзүүлэх замаар Монгол Улсын Засгийн газарт уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд тэсвэртэй ойн экосистемийг бүрдүүлэх, хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлж байна. НҮБ нь ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах стратеги боловсруулахад нь Монгол Улсын Засгийн газарт техникийн туслалцаа үзүүлж байна. Түүнчлэн НҮБ нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчимд нийцсэн ой, ус, газрын менежмент зэрэг байгалийн нөөцийг тогтвортой ашиглах талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (НҮБ БОХ), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБ ХХ), НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (НҮБ АҮХБ), НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн (НҮБ ССХ) зэрэг НҮБ-ын системийн таван байгууллагын хамтын санаачлага болох Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (PAGE)-д нэгдэж Монгол Улсын ногоон хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Энэхүү санаачлагын хүрээнд ТХЗ болон Ногоон эдийн засгийн нэгдсэн зарчим (IGE)-ыг тус улсын барилгын салбарын бодлогод тусгаж хэрэгжүүлэх, улмаар

орон нутгийн чадавхыг бэхжүүлэх зэрэг ажил хийж байна.

Тайлангийн хугацаанд НҮБ нь жижиг дунд үйлдвэрлэлийг бэхжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт өртөгийн сүлжээг хөгжүүлэх замаар ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэв. Үүний үр дүнд хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн махны үйлдвэрлэл 30 хувиар, хөтөлбөрт хамрагдсан сүү боловсруулах 10 үйлдвэрийн орлого 20 хувиар тус тус өссөн байна. Түүнчлэн хүнсний ногооны үйлдвэрлэлээ сайжруулахад нь зориулж 500 гаруй хүнсний ногоо тариалагчдад техникийн тусламж үзүүлснээр тэдний орлого 30 хувиар нэмэгдсэн. НҮБ нь 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэх, мөн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг гурван талтаар хэлэлцэхэд нь Монгол Улсын нийгмийн түншүүд болох Засгийн газар, ажилтны болон ажил олгогчдын байгууллагуудад техникийн туслалцаа, бодлогын зөвлөгөө өгсөн. НҮБ нь Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС) болон Ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн төр, засгийн бодлогод үнэлгээ хийж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй нийцүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд техникийн туслалцаа үзүүлсэн. 2030 оны Тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй бодлого стратегийг уялдуулах зорилгоор Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын чадавхыг өргөжүүлэн бэхжүүлж байна.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх, бүх нийтийг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамруулах, суурь боловсрол, ундны ус, ариун цэврийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн нотолгоонд суурилсан бодлого шийдвэр гаргаж нийгмийн салбарыг хөгжүүлэх зорилтоо хэрэгжүүлэхэд нь Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас техникийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн. НҮБ-ын системийн байгууллагууд, тухайлбал, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (НҮБ БШУСБ), НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБ ХС) болон Хөгжлийн түншүүд, тухайлбал, Азийн хөгжлийн банк (АХБ), Дэлхийн банк (ДБ) зэрэг байгууллагуудаас бүх түвшний боловсролын чанарыг сайжруулах, боловсролын салбарын төлөвлөлт, удирдлагын чадавхыг сайжруулах, Монгол Улсын ТХҮБ 2030-тай нийцүүлж боловсролын салбарын 10 жилийн мастер төлөвлөгөөг боловсруулахад нь Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн.

НҮБ-аас хоол тэжээлийн архаг дуталтай тэмцэх цогц менежментийн үндэсний протокол (ИММ) боловсруулах болон үндэсний чадавхыг бэхжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлсэн бөгөөд энэ нь хоол тэжээлийн хүнд хэлбэрийн архаг дуталтай (SAM) тэмцэхэд үр дүнгээ өгч

байна. Хоол тэжээлийн архаг дуталтай тэмцэх хөтөлбөрт 0-2 насны 19,300 хүүхэд, жирэмсэн болон хөхүүл 5,600 эмэгтэйчүүд хамрагдсан байна. Хөтөлбөр хэрэгжүүлсэн газруудад 2018 онд хоол тэжээлийн архаг дуталтай 57 хүүхдийг тэдний амь насыг нь аврах эмчилгээнд хамруулсан бөгөөд тэдний 88 хувь нь илааршиж эмчлэгдсэн байна. НҮБ-аас явуулсан судалгаагаар хүүхдүүдийн дунд илүүдэл жин, таргалалт нэмэгдэж байгаа нь хүүхэд болон насанд хүрэгчдийн эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл бий болж байгааг илэрхийлж байна.

Олон жилийн турш уйгагүй хийсэн шинжилгээ судалгааны ажил, НҮБ-аас өгч байсан зөвлөмжийн үр дүнд Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Үндэстний статистикийн хороо (ҮСХ), Иргэний бүртгэлийн газар зэрэг байгууллагууд хамтран төрөх газруудад хүүхдийг төрсөн даруйд нь албан ёсны бүртгэлд оруулж тэдний төрсөн цаг хугацаа, газар нутгийг үнэн зөв бүртгэх, шинээр төрсөн хүүхдүүдэд нийгмийн хамгааллыг цаг алдалгүй хүргэх тогтолцоог амжилттай бүрдүүлж чадсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, эрх зүйн зохицуулалтыг бүхий л түвшинд сайжруулах, ундны усны үнэ тарифыг тогтоох шинэ аргачлалыг нэвтрүүлэх чиглэлээр НҮБ-аас гаргаж буй хүчин чармайлтын үр дүнд хот суурин болон тэдгээрийн захын хорооллын айл өрхийн талаас илүү хувь нь ундны усаа боломжийн үнээр авч хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

2018 онд НҮБ-ын системийн байгууллагууд хамтран олон чиглэлээр судалгаа шинжилгээ хийж мэдээлэл цуглуулсны үндсэн дээр Улаанбаатар хотын агаарын бохирдол, хүүхдийн эрхийг хамгаалах талаар сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг хийсэн.

НҮБ нь төрийн үйлчилгээний хариуцлагыг бэхжүүлэх, ядуу, эмзэг бүлгийнхний хууль, эрх зүйн хамгааллыг хангах чиглэлээр олон алхам хийсэн. НҮБ нь орон нутгийн засаглалд нөлөөлж буй үндсэн хуулийн болон эрх зүйн шинэтгэлийн талаархи яриа хэлэлцүүлгийг өрнүүлэхэд

хувь нэмрээ оруулсны нэг жишээ бол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг үндсээр нь шинэчлэх үндэс суурийг тавьсан явдал юм. Сонгуультай 2000 гаруй эмэгтэй төлөөлөгчдөд улс төрийн шийдвэр гаргахад илүү үр дүнтэй оролцох боломжийг олгож эрх мэдэлжүүлэх зорилгоор Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтад хамруулж ажиллаа.

НҮБ-ын зүгээс тус улсад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд томоохон ахиц дэвшил гаргасан. НҮБ нь Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)-тай хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, уг хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бүх талууд нэгдэн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар олон ажил хийсэн. Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын хамтын дэмжлэгтэйгээр 2018 онд Хөвсгөл, Баян-Өлгий, Хэнтий, Дархан-Уул, Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг зэрэгт нийт таван Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ) байгуулагдсан бөгөөд одоогоор Монгол Улсад нийтдээ 11 НЦҮТ тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

НҮБ нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор дэлхийн нийт улс орнуудад үзүүлж байгаа тусламж дэмжлэгтээ үнэлэлт өгч, хэрэгжилтэд нь хяналт тавих замаар өөрийн хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлж байна. Монгол Улс дахь НҮБ нь өөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн бодит явцыг Тогтвортой хөгжлийн 17 зорилго нэг бүртэй уялдуулан хянаж байх НҮБ-ын шинэ онлайн систем болох UNInfo-д холбогдох мэдээллийг байршуулж эхлээд чамгүй хугацаа өнгөрч байна.

Монгол Улс дахь Нэгдсэн үндэстний системийн байгууллагууд нь эдийн засгийн цар хүрээгээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ, үйл ажиллагааныхаа зардлыг бууруулахад анхаарч НҮБ-ын нийтлэг бизнесийн үйл ажиллагаагаа ахисан түвшинд гаргах үйл хэргээ үргэлжлүүлэн ажиллаж байна.

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

Хөтөлбөрийн үр дүн гэсэн энэхүү хэсэгт НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (ХТХ)-нд хүрэхийг зорьсон үр дүнгийн гурван үндсэн чиглэлд дэвшүүлсэн 12 үндсэн зорилгын хэрэгжилтийн явцыг тайлагнаж байна.

НҮБ-ЫН ХТХ-НИЙ ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 1

Хүртээмжтэй өсөлт, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих;

Зорилго 1.1 ТХЗ-той уялдуулсан хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, стратеги, төлөвлөгөөг боловсруулах; ингэхдээ ядуурлыг бууруулах, хүртээмжтэй өсөлт, эдийн засгийг төрөлжүүлэх, үндэстний болон орон нутгийн түвшинд эрсдлийг даван туулахад бэлтгэлтэй байх нөхцөлийг бүрдүүлэх зэргийг тэргүүлэх чиглэлээ болгох;

Зорилго 1.2 Зохистой ажлын байр, ур чадварыг бий болгох, цэвэр технологийг нэвтрүүлэх, байгаль орчны доройтол, байгаль орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх, ядуурлыг бууруулах зэрэгт чиглэсэн ногоон эдийн засгийн үндэстний стратегийг боловсруулж Монголын онцлогт тохирсон, ард иргэдийн оролцоонд тулгуурласан уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох, түүний нөлөөллийг бууруулах арга хандлагыг нэвтрүүлэх;

Зорилго 1.3 Хөдөө орон нутгийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг тэтгэдэг экосистемийн үйлчилгээг хамгаалах;

Зорилго 1.4 Нутгийн иргэдийн гамшгийн эрсдлийг даван туулах чадварыг сайжруулах

НҮБ-ЫН ХТХ-НИЙ ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 2

Нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш хүртээмжтэй нийгмийн үйлчилгээг бий болгох;

Зорилго 2.1 Технологийн шийдэл, ус, ариун цэврийн байгууламжийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх замаар илүү таатай орчин бүрдсэн, мэдээлэл судалгаатай, нийгмийн ухамсараар дэмжигдсэн Ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сонгогдсон хотын захын хороолол болон сумдад сайжруулах;

Зорилго 2.2 Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхийн тулд хот суурин, хотын захын хороолол болон хөдөө орон нутгийн ядуу, эмзэг хүн амын эрүүл мэндийг сайжруулах; эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээнд хүн бүр тэгш хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх; нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргахад үндэстнийхээ байгууллагуудтай хамтран ажиллахыг дэмжих;

Зорилго 2.3 Илүү чанартай суурь боловсролыг дэмжиж, хүүхдийг бага наснаас нь хөгжүүлэх, улмаар насан турш боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хотын захын хорооллын сонгогдсон хэсгүүд, зарим сумдад хэрэгжүүлэх;

Зорилго 2.4 Нийт хүн амыг, ялангуяа, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг түлхүү хамруулсан үр ашигтай, үр нөлөөтэй нийгмийн хамгааллын тогтолцоог нэвтрүүлэх,

Зорилго 2.5 Хүнс болон хоол тэжээлийн аюулгүй байдлыг бэхжүүлэх (эрүүл хүнс/тэжээлийн орчинг бүрдүүлэх, хоол тэжээлийн дутлын эрсдлийг эрс бууруулах, хүнс, хоол тэжээлийн тандан судалгаа, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх).

НҮБ-ЫН ХТХ-НИЙ ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 3


Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлэх

Зорилго 3.1 Хүний эрхийг хамгаалах, ялангуяа, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах зорилгоор олон улсын стандартад нийцүүлэн хууль эрх зүйн шинэчлэл хийж хяналтын тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх замаар хууль эрх зүйн хамгааллын механизмыг сайжруулах,

Зорилго 3.2 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд, залуучуудын (34 хүртэлх насны) төлөөллийг нэмэгдүүлэх, тухайлбал, Монгол Улсын Их хурал, яамдын сайд, төрийн нарийн бичгийн дарга, аймгийн засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгчдийн түвшинд;

Зорилго 3.3 Залуучуудын холбоо, байгууллагуудыг бэхжүүлэх, тэдний санаа бодлоо эрх тэгш түншийн хувьд чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих.



НИЙТ
ЗАРЦУУЛАЛТ,
ҮР ДҮНГЭЭР,
ЖИЛЭЭР



- Үр дүн 3: Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлэх
- Үр дүн 2: Нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш хүртээмжтэй нийгмийн үйлчилгээг бий болгох;
- Үр дүн 1: Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлэх



©ДЭМБ



ХЭРЭГЖҮҮЛСЭН ГАЗАР НУТАГ

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ




ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ЭХНИЙ 10

ЗАРЦУУЛАЛТ



ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД ЭХНИЙ 10

ЗАРЦУУЛАЛТ



ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 1



ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 ОН ГЭХЭД ЯДУУ БОЛОН ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМЫН ГЭНЭТИЙН ГАМШГИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАР НЭМЭГДЭЖ, ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, ЭРҮҮЛ ЭКОЛОГИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР ШИМИЙГ ЭДЭЛНЭ

НҮБ нь Монгол Улсын хөгжлийн бодлогын хүрээг тодорхойлох, институцийн тогтолцоог хөгжүүлэх, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангах үндэсний чадавхыг бий болгоход чиглэсэн техникийн туслалцаа үзүүлсээр ирсэн билээ. НҮБ-ын системийн 10 байгууллага нийтдээ 31.7 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилт босгоод байгаагаас 22.14 сая ам.долларын хөрөнгийг 33 түнш байгууллагуудтайгаа хамтран 15 аймаг, нийслэл Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа 40 төсөл хөтөлбөрийн

үйл ажиллагаанд зарцуулсан байна. Нийт зарцуулалтын 87 хувь нь ТХЗ 15–Хуурай газрын экосистемийг хамгаалах, ТХЗ 2– Өлсгөлөнг эцэслэх, ТХЗ 12– Хариуцлагатай хэрэглээг дэмжих, ТХЗ 13– Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, ТХЗ 11– Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих, ТХЗ 8– Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих, ТХЗ 17– Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэг долоон ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулагдсан байна.

ТӨР ЗАСГИЙН БОДЛОГЫГ ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДУУЛАХ

НҮБ нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх талаар цогц шийдлийг олох системийн шинжилгээг хөгжүүлэх, ТХЗ-ын зорилтот түвшинг тодорхойлж үндэсний хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд тусгах, эдгээр зорилт хоорондын харилцан уялдаа холбоог тогтоох, улсын төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулж улмаар ТХҮБ болон ТХЗ-ын үндсэн зорилтуудыг хангах зэрэг чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газар нь улсын төсвөө боловсруулахдаа ТХЗ-той уялдуулах туршилтыг хийж эхэлсэн нь бүс нутгийн түвшинд шинэ хандлага тогтоосны зэрэгцээ хөтөлбөрт суурилсан төсвийн хуваарилалтын чухал элементүүдийг нэвтрүүлж, төсвийн стратегийн хуваарилалтын үүрэг функцийг сайжруулсан. Энэ нь тус улсын ТХЗ-ын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлд

үнэлгээ өгөхөд тус болно. Салбар хоорондын уялдааг хангах загварчлалын арга хэрэгслийг боловсруулах, ТХЗ-ын интерактив мэдээллийн системийг боловсруулж ашиглах, улсын хэмжээнд судалгаа хийж бүрэн бодитой мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах зэрэг чиглэлээр ҮСХ болон Үндэсний хөгжлийн газарт НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын улс төрийн хүчин чармайлт, санхүүгийн дэмжлэгтэйгээр, анх удаа Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Засгийн газар хоорондын байгууллага (Олон улсын бодлогын судалгааны төв) байгуулагдаж далайд гарцгүй орнуудын ашиг сонирхлыг төлөөлөн тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлт, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх зэрэг хөгжлийн асуудлаар ажиллаж байгаа нь мэдлэг мэдээлэл, судалгаа

шинжилгээ, хөрөнгө нөөцийн үр ашгийг сайжуулах үр дүнтэй ажиллагаа (платформ) болж байна. Энэхүү байгууллагын үндэс суурийг тавих зорилгоор НҮБ-аас тус төвийн Нарийн бичгийн даргын түр албыг байгуулж хамтарсан санхүүжилттэй төслөөр дамжуулан үйл ажиллагааг нь дэмжин хөгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлж чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Түүнчлэн өнгөрсөн жилүүдэд энэхүү Олон улсын бодлогын судалгааны төвийн гишүүнчлэлийн болон олон улсын нөлөө нь тогтвортой өсч байлаа. Олон улсын бодлогын судалгааны төв нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейд албан ёсны ажиглагчийн статустай болсон нь тус төв нь гишүүн орнуудыхаа хөгжлийн онцлог хэрэгцээ шаардлагыг хангах чадавхитай болсон төдийгүй, дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх боломж бололцоотой болсныг нь хүлээн зөвшөөрсний илэрхийлэл

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАМНАЛЫГ ДЭМЖИХ

Монгол Улсын Засгийн газар нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн ээдрээтэй олон сорилт бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор ногоон болон тогтвортой хөгжлийн замналыг тууштай хэрэгжүүлэхээр зорьж байна. Хөгжиж байгаа орнуудын ойн хомсдол, доройтлоос үүдсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн НҮБ-ын хамтарсан хөтөлбөр (UNREDD)-ийн техникийн болон зөвлөх үйлчилгээний дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар нь Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний стратегиа боловсруулж, хэрэгжүүлэх арга хэрэгслээ

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ

НҮБ нь бодлого боловсруулах болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн ой, ус, газрын тогтвортой менежмент зэрэг байгалийн нөөцийг зохистой ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж, эрчим хүчний хэмнэлттэй барилгын загвар, экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээ зэрэг хэд хэдэн санаачилга эерэг үр дүнгээ өгч байна. Монгол Улсын Засгийн газрын санаачлага, санхүүгийн дэмжлэгтэйгээр НҮБ-аас тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх мэдээллийн санг бий болгох, байгаль орчны хяналт шинжилгээ хийх, хүлэмжийн хийн тооллого явуулах зэрэг асуудлаар мэргэжлийн туслалцаа үзүүлсэн. Байгалийн нөөц болон биологийн олон янз байдлын ашиг тусыг өнөөгийн болон хойч үеийнхэн адил тэгш

юм. Олон улсын бодлогын судалгааны төв нь олон улсын манлайлагч байгууллагуудтай түншлэлийн харилцаа холбоог амжилттай хөгжүүлж, өөрийгөө Далайд гарцгүй орнуудын талаарх дэлхийн хэмжээний мэдлэгийн платформ болгож чадсан юм. Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын бодлогын судалгааны төв (LLDC ITT) нь олон улсын өндөр түвшний хэд хэдэн арга хэмжээ, семинар зохион байгуулж, бүс нутгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хэд хэдэн судалгааны тайланг гаргасан. Эдгээр бүтээл нь тус төвийн нэр хүнд өсөхөд дэм болсон бөгөөд тус төв нь Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, бизнес, санхүү, худалдааны асуудлаарх судалгааны гол институтц болж хүлээн зөвшөөрөгдөх болсон.

тодорхойлоод байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд тэсвэртэй ойн экосистем, хүн амын амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилготой энэхүү стратегиар ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний боломжит хувилбаруудыг тодорхойлсон болно. Түүнчлэн Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенцийн хүрээнд тавигддаг шаардлагыг хангаж, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн урамшуулал хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх үндэсний чадавхыг бий болгоход НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж байна.

хүртэх боломж нөхцөлийг хангахын тулд Монгол Улс нь экосистемийн үйлчилгээг удирдах, хамгаалахад чиглэсэн төлөвлөлт, төсөвлөлтийг цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын Засгийн газрын энэхүү зорилтоо хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор НҮБ-аас Биологийн олон янз байдлын санхүүжилтийн төлөвлөгөө боловсруулж, байгалийн нөөцийн татварыг шинэчлэн тогтоох, бэлчээрийн төлбөрийг дахин сэргээх, Байгаль орчны итгэмжлэлийн сан байгуулах зэрэг санхүүжилтийн шийдлийн хувилбаруудыг тодорхойлсон болно. Энэ үүднээс Монгол Улс нь олон улсын албан ёсны сайтуудын сүлжээ (Biosphere Reserves, Global Geoparks & World Heritage sites)-нд нэгдэхийн тулд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, менежментээ сайжруулах чиглэлээр НҮБ-аас дэмжлэг туслалцаа авч байна.

ГАМШГИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

Монгол Улсын гамшгийн эрсдлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, гамшгийн эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хандлагыг өөрчлөх, малчдын бэлэн байдлыг сайжруулахад чиглэсэн тусламж дэмжлэгээ НҮБ хэвээр үргэлжлүүлж байна. НҮБ-ын Гамшгийн эрсдлийг бууруулах арга хэмжээний хөтөлбөрийн гол зорилго нь гантай зуны хэт хуурайшилт, өвлийн тэсгим хүйтрэл зэрэг цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж нэмэгдэх болсон өнөөгийн нөхцөлд ард иргэдийн бэлэн байдлыг урьдчилан хэвшүүлэх замаар


цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн үед хөдөө, хотын хүн амын эмзэг байдлыг бууруулахад оршиж байгаа юм. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар (ОБЕГ) нь бизнесийн байгууллагатай (Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо) хамтран Монголын аж ахуйн нэгж байгууллага, жижиг дунд үйлдвэрийн гамшгийн эрсдлийн удирдлагын тогтолцоо, бизнесийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах гарын авлагыг боловсруулан баталж гаргасан¹.

¹ <http://nema.dri.gov.mn/mainnews/2146/>


ЗОРИЛГО 1:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 1:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 1:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР





unicef



UN HABITAT
UNITED NATIONS HUMAN SETTLEMENTS PROGRAMME



Зорилго

1.1

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТТОЙ УЯЛДУУЛСАН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, АЛСЫН ХАРАА, СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ; ИНГЭХДЭЭ ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ЭРСДЛИЙГ ДАВАН ТУУЛАХАД БЭЛТГЭЛТЭЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗЭРГИЙГ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭ БОЛГОХ;



Төсвийн төлөвлөлт, үндэсний мэдээллийн системд ТХЗ-ыг тусгах

НҮБ нь Сангийн яам (СЯ), Үндэсний хөгжлийн газар (ҮХГ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Улаанбаатар хотын захиргаатай хамтран ТХЗ-ыг үндэсний болон орон нутгийн түвшинд нутагшуулан хэрэгжүүлэх үйлсийг манлайлан ажиллаж байна. ТХЗ-ыг тусгасан урт хугацааны төсвийн төлөвлөгөөг боловсруулах зорилго агуулан НҮБ-аас Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ хийж хөгжлийн санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны ерөнхий тойм, төсөв санхүүгийн хуваарилалтыг үндэсний хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулах талаар бодлогын зөвлөмжийг гаргасан болно. Түүнчлэн НҮБ нь өнөөгийн хэрэгжиж байгаа үндэсний хөгжлийн бодлого, ТХҮБ-ын уялдаа, салбарууд хоорондын бодлогын уялдаанд үнэлгээ хийхэд ҮХГ-т дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн төсвийн стратегийн хуваарилалтын үйл ажиллагааг сайжруулах, ТХЗ, ТХҮБ-ын зорилго зорилтуудыг хэрэгжүүлэхэд төсвийн санхүүжилтийг чиглүүлж үр ашгийг нь сайжруулах зэргээр Улсын төсвийн санхүүжилтийн менежментэд шинэчлэл хийх боломжийг судалсан болно. Ингэхдээ СЯ, ЭМЯ зэрэг яамдын төсөв боловсруулах явцад хөтөлбөрт суурилсан төсвийн элементүүдийг аажмаар нэвтрүүлэх, эхний ээлжинд туршилт хийж байгаа яамдын бодлогын газруудыг ТХЗ-д суурилсан тэргүүлэх чиглэлийг тогтоох, төсвийн төлөвлөгөөг боловсруулахад татан оролцуулж улмаар дунд хугацааны төсвийн төлөвлөгөөг сайжруулахад чиглүүлэх зэрэг ажлуудыг хийж байна.

“Зохистой хөдөлмөрийг дэмжиж 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь: ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, улс орны төлөв байдал” гэсэн тайланг боловсруулж, Монгол Улсын

зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүдэд гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийж, ТХЗ-ын хэрэгжилтийг хянах суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох чиглэлээр НҮБ-аас ҮСХ-нд техникийн туслалцаа үзүүлсэн. Түүнчлэн ҮСХ нь Ажиллах хүчний судалгааны шинэ аргачлалыг Олон улсын хөдөлмөрийн статистикчдын хурлаас гаргасан зөвлөмжтэй нийцүүлэн боловсруулж 2017, 2018 онуудад туршсан болно. ҮСХ нь Олон улсын судалгааны хөтөлбөр (MICS)-т суурилсан Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ нь ТХЗ-ын нийт 32 шалгуур үзүүлэлтүүдийн суурь үзүүлэлтийг бүрдүүлж өгсний зэрэгцээ эдгээр үзүүлэлтүүдийг өөр өөр түвшинд, төрөл бүрийн шинж байдлаар нь задалж тооцох боломжийг бүрдүүлж байгаа юм. Үүний зэрэгцээ НҮБ-ын дэмжлэгтэйгээр ТХЗ-ын мэдээллийн экосистемийн үнэлгээ хийсэн нь үндэсний бүх талуудад ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт шинжилгээнд уламжлалт бус мэдээллийн эх үүсвэрийг ашиглах боломжийг нээж өгсөн. Мөн ТХЗ-4-ын хүрээнд дэвшүүлэх зорилт, шалгуур үзүүлэлт, боловсролын талаарх тоо мэдээллийг цуглуулах, Боловсролын удирдлагын мэдээллийн систем (EMIS) –ийг ашиглан тайлагнах, дүн шинжилгээ хийх тогтолцоог сайжруулах чиглэлээр БСШУЯ-ны чадавхыг бэхжүүлэхэд НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн.



Ээлтэй хот, иргэд олон нийтийн оролцоо

Ард иргэдийнхээ оролцоог дэмжиж, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдад ээлтэй, өрсөлдөх чадвартай, хүртээмжтэй дэд төвүүдийг байгуулах зорилго агуулсан Нийслэл Улаанбаатар хотын үйл ажиллагаанд НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд 13.42 км төвлөрсөн дулааны шугам хоолой, 3,2 км шинэ халаалтын шугам, 7.58 км дулааны шугам сүлжээ, 26.8 мегаваттын хүчин чадал бүхий цахилгаан станц, ус, дулаан дамжуулах 26 дэд станц барих зэрэг

Хотын дэд бүтцийн олон төслүүдийн төлөвлөгөө гаргах, зураг төсөл боловсруулах явцад эмэгтэйчүүд, өндөр настан, бүх төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг эмзэг бүлгийн хүн амын төлөөллийг хамруулан хүн амын бүлгүүдтэй өргөн хүрээнд хэлэлцэж зөвлөлдсөн. Нийслэл хотын гэр хороололд боломжийн үнэ өртөг бүхий орон сууц, хотын дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор Техникийн туслалцааны нэг хэсэг болгон үйл ажиллагааны төлөвлөгөө, ядуурлыг бууруулах, нийгмийн хөгжлийн стратегийг боловсруулсан.



©ДЭМБ

Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлт

Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дорнод зэрэг зургаан аймгийн газар тариалангийн салбарт өртгийн сүлжээг хөгжүүлж, ажлын байр бий болгох санаачлага олон арван өрхөд ашиг тусаа өгсөн. Төсөлд хамрагдсан өрхүүдийн мах үйлдвэрлэл 30 хувиар, сүү цагаан идээ боловсруулах 10 аж ахуйн нэгжийн орлого 20 хувиар, хүнсний ногооны үйлдвэрлэл сайжирсны үр дүнд хүнсний ногоо тариалдаг 500 гаруй ногоочдын орлого 30 хувиар тус тус өссөн байна. Хосолсон сургалтын хөтөлбөр, бусад

олон төрлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар дээшилж, зах зээлийн холбоо сүлжээг бүрдүүлж чадсан. НҮБ-аас хэрэгжүүлсэн Идэвхжсэн 2030 санаачилгаар дамжуулан залуу хүмүүсийн аж ахуй эрхлэх чадамжийг сайжруулах зорилгоор Төсөөлөх сэтгэлгээ (Design Thinking), Зан үйлийн өөрчлөлт (Behavioral Insights), Мэдээлэл солилцох хандлага (Platform Approach) зэрэг шинэлэг үйл ажиллагааг НҮБ-аас дэмжиж ажилласан.

Дотоод шилжилт хөдөлгөөний менежментийг сайжруулах


Тэгш бус байдлыг арилгаж, иргэддээ ээлтэй хот, хамт олны хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор шилжилт хөдөлгөөнийг удирдан зохицуулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт үзүүлэх тусламжаа НҮБ үргэлжлүүлж ирсэн. Үүнд дотоодын шилжилт хөдөлгөөн (хөдөөгөөс хот руу)-ий асуудлыг шийдвэрлэх, хүмүүс сайн дураар буцаж шилжих нөхцөлийг бүрдүүлэх, улмаар эргэж

ирээд дахин суурьшихад нь тулгарах бэрхшээлийг даван туулахад нь туслах зэрэг асуудлыг хамруулсан. Дотоод шилжилт хөдөлгөөний талаарх судалгааг 2 удаа хийсэн бөгөөд уг асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах бодлогын зөвлөмж боловсруулж, шилжилт хөдөлгөөний менежментийн талаар төр, засгийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.


ЗОРИЛГО 1.1:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 1.1:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 1.1:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ, САНГИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 1.1:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

Монгол Улсын Их хурал, БОАЖЯ, ХХААХҮЯ, ХНХЯ, ЭМЯ, БСШУЯ, ҮСХ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Стандарт, хэмжил зүйн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Орон нутгийн захиргаад, МҮЭХ, МАОЭНХ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн, АХБ, НҮБ ХХ

Зорилго 1.2

3 ОХИСТОЙ АЖЛЫН БАЙР, УР ЧАДВАРЫГ БИЙ БОЛГОХ, ЦЭВЭР ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ДОРОЙТОЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРСДЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЗЭРЭГТ ЧИГЛЭСЭН НОГООН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙГ БОЛОВСРУУЛЖ МОНГОЛЫН ОНЦЛОГТ ТОХИРСОН, АРД ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ДАСАН ЗОХИЦОХ, ТҮҮНИЙ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХАНДЛАГЫГ НЭВТРҮҮЛЭХ;



Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлогын суурь мэдээллийг тодорхойлох


Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлого, шийдвэр, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үндэслэл болохуйц тоо мэдээлэл цуглуулах ажлыг НҮБ-аас дэмжиж ажилласан. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран Оксфордын бодлогын менежментийн газраас (олон улсын хөгжлийн зөвлөх компани) мэргэжилтнүүдийг урьж агаарын бохирдлыг бууруулах талаар улсын төсвийн хөрөнгөөр дорвитой алхам хийхгүй байх нөхцөлд хүүхдийн эрүүл мэндийн асуудалтай холбоотойгоор гарч болзошгүй өртөг зардалд дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн. Энэхүү судалгааны үр дүнгээр бодлогын хойшлуулшгүй арга хэмжээ авах нь нэн чухал болохыг нотлон ил гаргаж тавьсан нь агаарын бохирдлыг бууруулах улс төрийн хүчин чармайлт гаргахад тодорхой нөлөөлөл үзүүлсэн². Үүний зэрэгцээ, агаарын бохирдлыг бууруулахад зарцуулж байгаа улсын төсвийн хөрөнгийн судалгаа хийж өнгөрсөн жилүүдийн хөрөнгө

оруулалтын үр нөлөөг судалж, цаашдын тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн. Энэхүү судалгааны хүрээнд түүхий нүүрснээс хэт хамааралтай байгаа эрчим хүчний салбарт өөрчлөлт хийх боломжит хувилбаруудын судалгааг мөн хийсэн. Үүний зэрэгцээ тус улсын хэмжээнд агаарын бохирдолтой тэмцэх үр дүнтэй шийдлийг олохын тулд НҮБ нь хувийн арилжааны банктай хамтран ажиллаж байна. Энэхүү санаачилгын хүрээнд нийслэлийн замын хөдөлгөөнийг оновчтойгоор зохицуулах, халаалтын технологийн шинэ хувилбаруудыг турших арга хэмжээ авч байна. НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт Барилгын салбарын хяналт шинжилгээ, баталгаажуулалт, тайлагналт, хүлэмжийн хийн ялгарлын талаарх мэдээллийн санг бий болгох, барилга байгууламжийн эрчим хүчний хэмнэлтийг сайжруулах туршилтын/демо төслийг хэрэгжүүлэхэд мөн дэмжлэг үзүүлсэн.

Ойн хомсдол, доройтлолтой тэмцэх

НҮБ-ын REDD хөтөлбөр (хөгжиж байгаа орнуудын ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах)-өөс Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн хүрээнд хүлээсэн

үүргээ биелүүлэхэд чиглэсэн хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн. Энэ хүрээнд, Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний стратеги (Үндэсний REDD стратеги)-ийг



©НҮБ ХХ

² "Аюулын харанга: Агаарын бохирдол ба хүүхдийн эрүүл мэнд", НҮБ ХС, 2018

боловсруулахдаа үндэсний чадавхыг бэхжүүлэх, ойн хомсдол, доройтлыг өдөөж буй хүчин зүйлүүдэд дүн шинжилгээ хийх, оролцогч талуудыг тодорхойлж зураглал гаргах, институцийн бүтцийн үнэлгээ хийх, боломжит санхүүжилтийн механизмыг судлах зэрэг ажлуудыг хийсэн. Түүнчлэн Ойн тооллогын үндэсний мэдээллийн сан (NFI)-г 123,000 нэгж ойн санг хамруулан судалж

Ногоон хөгжлийн хөтөлбөр

Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (PAGE) хөтөлбөрөөр дамжуулан ТХЗ-ыг хэрэгжүүлэхийг дэмжих, уялдуулах, ногоон эдийн засгийн нэгдсэн зарчмуудыг барилгын салбарын бодлогод тусгах, үндэсний чадавхыг бэхжүүлэх зэргээр НҮБ-аас Монгол Улсын Ногоон хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсээр ирсэн. Түүнчлэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, ногоон хөгжлийн зарчмуудыг МУИС, ХААИС, СЭЗИС, ХБИС сургуульд хэрэгжүүлж байгаа дээд боловсролын сургалтын

Уур амьсгалд ээлтэй орчин

Хог хаягдлын менежментийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан НҮБ-аас үндэсний болон нийслэл хотын хог хаягдлын менежментийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Эдгээр стратегийг боловсруулахдаа олон талын зөвшилцөл, идэвхтэй оролцоог хангаж ажилласны зэрэгцээ, хог хаягдал болон уур амьсгалын өөрчлөлтийн харилцан уялдаа холбоог тодорхойлж тусгасан болно. Хөтөлбөр хэрэгжүүлсэн туршилтын бүсэд хог хаягдлын нийт овор хэмжээ 68.75 хувиар, жин 57.13 хувиар тус тус буурсны үр дүнд хог хаягдал цуглуулах, тээвэрлэх зардал, хог тээврийн ачаа эргэлт, тээвэрлэлтийн давтамж ихээхэн

шинэчлэн бүрдүүлэхэд НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн. Хяналт шинжилгээ, тайлагналт, баталгаажуулалтын (MRV) системийг тодорхойлсноор хүлэмжийн хийн (GHG-I) ялгаралд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар тайлан мэдээлэл гаргах боломж бүрдсэн. Монгол Улсын REDD++ Хамгааллын үндэсний хүрээг мөн холбогдох талуудтай зөвшилцөн боловсруулсан болно.


хөтөлбөрт тусгасан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Төрийн ногоон худалдан авалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад НҮБ-аас СЯ-нд техникийн туслалцаа үзүүлсэн. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, тендерийн баримт бичгийг үнэлэхэд ногоон шалгуур үзүүлэлтийг ашиглахыг журамлаж өгсөн болно.

хэмжээгээр буурсан. Цөмийн шинжлэх ухаан, технологи нь ихээхэн өргөн цар хүрээтэй хэрэглээ гэдгийг хүлээн зөвшөөрч НҮБ нь Олон улсын цөмийн эрчим хүчний байгууллага (МАГАТЭ)-ын мэргэжлийн туслалцаатайгаар Монгол Улсын Цөмийн мэдлэгийн менежментийн хөтөлбөр (NKM)-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Энэхүү хамтын ажиллагаа нь холбогдох их дээд сургууль, байгууллагуудын зохион байгуулалтын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэж байгаа бөгөөд цөмийн мэдлэгийн менежментийн системтэй арга хандлагыг төлөвшүүлэхэд туслах замаар уур амьсгалд ээлтэй арга зүйг хөгжүүлэх, тогтвортой судалгаа шинжилгээ хийхийг дэмжих зорилготой юм.


ЗОРИЛГО 1.2:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 1.2:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 1.2:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ, САНГИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 1.2:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

БХБЯ, УУХҮЯ, БОАЖЯ, ХНХЯ, ОБУГ, Орон нутгийн захиргаад, Монголын ажил олгогч, эздийн нэгдсэн холбоо, МУИС-ын Цөмийн судалгааны төв, МУИС, Азийн сан, МҮЭНХ, Гэр хорооллын зураглалын төв (Ger Community Mapping Center Mongolia), Олон улсын байгаль орчин технологийн төв



Зорилго 1.3

Хөдөө орон нутгийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг тэтгэдэг экосистемийн үйлчилгээг хамгаалах;



Байгаль орчныг хамгаалах

Хамтын оролцоотой ойн тогтвортой менежмент (PFM)-ийн институцийн бүтэц, бодлого, зохицуулалтын тогтолцоог боловсруулахад НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт техникийн туслалцаа үзүүлсэн. Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд 460,000 га талбай бүхий ойг хамарсан 5 аймгийн зуун нэгэн Ой ашиглагчдын бүлгүүдэд (FUG) ойн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн болоод ложистикийн дэмжлэг үзүүлсэн. Нийт 500 гаруй га ойн талбайд Ой ашиглагчдын бүлгүүд цэвэрлэгээ хийснээр ойн төлөв байдал сэргэн сайжирч, ой ашиглагчдын орлого ч нэмэгдсэн.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн (LPA) мэдээллийн санг байгуулсан нь хууль эрх зүйн зөрчилтэй асуудлуудыг, ялангуяа, уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн зөрчил маргаан, гео координатын системд гарсан зөрүүтэй үйлдлүүдийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой болсон

хэмээн хөндлөнгийн үнэлгээний багийнхан үнэлсэн байдаг. 2018 оны эцсийн байдлаар нийт бүртгэлтэй Орон нутгийн тусгай хамгаалалттай 2593 газар нутгийн 1,361 нь хууль эрх зүйн зөрчил маргаангүй байна. Энэ нь 2014 оны суурь үзүүлэлттэй харьцуулахад орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хууль эрх зүйн зөрчил 41 хувиар буурсан болохыг харуулж байна. буюу Монгол Улсын нийт газар нутгийн 15.13 хувийг бүрдүүлж байгаа юм. Энэхүү өргөн цар хүрээтэй Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг үр дүнтэй удирдах нь нэн чухал асуудал болж байна. Мэдээллийн санг Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Ус цаг уур, орчны хүрээлэн зэрэг дөрвөн талтын хамтын хэлэлцээрээр байгуулж амжилттай хэрэгжүүлж байна. Тус мэдээллийн санг Байгаль орчны менежментийн төвөөс удирддаг мэдлэгийн платформтой нягт уялдуулан ажиллуулж байна.

Экосистем болон биологийн олон янз байдлыг хамгаалах

Био-мониторингийн 24 удаагийн судалгааны үр дүнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны амьд амьтан, ургамлын мэдээллийн санд 118 төрлийн мэдээллийг нэмж оруулснаар амьтан, ургамлын судалгаа, шинжилгээний ажилд ашиглах улсын байгаль орчны мэдээллийн санг ихээхэн хэмжээгээр баяжуулсан юм. Түүнчлэн энэ мэдээллийн санг биологийн олон янз байдлыг хамгаалах менежмент, бодлогын төлөвлөлт, шинэчлэлт хийхэд ашиглаж байна. Экосистемд суурилсан дасан зохицох арга хэмжээг авч явуулсны үр дүнд байгалийн 44 булгийг сэргээснийг хөндлөнгийн үнэлгээний тайланд тэмдэглэсэн. Орон нутгийн иргэд хэрэглэх, мал сүрэг ундаалах устай болж, ашиглагдахаа больсон 96000 орчим га бэлчээрийн талбайг дахин ашиглах болсон нь 184,000 толгой мал бүхий 6,600 орчим хөдөө орон нутгийн иргэдэд

ашиг тусаа өгч байна. Мөсөн гол, гол мөрөн, хөрсний ус, цаг агаарын байдлыг хянах хяналтын цэгүүд байгуулах замаар төр засгийн төв орон нутгийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх сургалт зохион байгуулахад НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн.

Бодлогын болон институцийн тогтолцоонд хийсэн үнэлгээ (PIR), Биологийн олон янз байдлын зардлын үнэлгээ (BER), Санхүүжилтийн хэрэгцээний үнэлгээ (FNA) зэрэг судалгааны үр дүнд үндэслэн Биологийн олон янз байдлын санхүүжилтийн төлөвлөгөө (BFP) боловсруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлэв. Гэхдээ энэхүү төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Монгол Улс нь санхүүжилтийн шинэлэг шийдлийг олох шаардлагатай байна. Түүнчлэн, байгалийн нөөцийн татварыг шинэчлэн


тогтоох, бэлчээрийн төлбөрийг дахин сэргээх, Байгаль орчны итгэмжлэлийн сан болон Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн тогтвортой санхүүжилтийг

бий болгох зэрэг санхүүжилтийн дөрвөн хувилбарыг турших төслийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн.


ЗОРИЛГО 1.3:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 1.3:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 1.3:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 1.3:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

БОАЖЯ, БСШУЯ, Ойн судалгаа, хөгжлийн төв, Монгол Улсын Ой ашиглагчдын бүлэг



Зорилго 1.4

НУТГИЙН ИРГЭДИЙН ГАМШГИЙН ЭРСДЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ



Онцгой байдлын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, гамшгийг хохирол багатай даван туулах

Гамшгийн эрсдлийг бууруулах талаар Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны арга хандлагыг өөрчлөх, ган, зуд гэх мэт цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж нэмэгдэх болсон нөхцөлд малчдын сэрэмж, бэлэн байдлыг сайжруулах зэргээр Монгол Улсын Онцгой байдлын удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд НҮБ-аас үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлж байна. НҮБ-ын дэмжлэгтэйгээр тус улсын хэмжээнд гамшгийн эрсдэлд өртөх магадлалтай ард иргэдэд цаг агаарын ноцтой үзэгдлийн талаар цаг тухайд нь шуурхай мэдээлэх Эрт сэрэмжлүүлгийн системтэй болсон. НҮБ, ОБЕГ-аас боловсруулсан ухаалаг утасны аппликейшнийг гамшгийн эрсдлийг бууруулах, улмаар хариу арга хэмжээ авахад шаардагдах ур чадварыг олон нийтэд эзэмшүүлэхэд өргөнөөр ашиглаж байна. Түүнчлэн, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшигт үзэгдлийн нөлөөллийг бууруулах чиглэлээр хариу арга хэмжээ авах үндэсний чадавхи, зохицуулалтын механизм сайжирч байна. НҮБ-аас Онцгой байдлын төвлөрсөн сангаар дамжуулан зудад нэрвэгдсэн 4000 малчин өрхөд тусламж үзүүлсэн. Эдгээр өрхүүдийн нийт хүн ам 14,567 байсан бөгөөд тэдний 45 хувь нь эмэгтэйчүүд, 55 хувь нь эрэгтэйчүүд байсан. Тэдгээрийн дунд 147 жирэмсэн эмэгтэйчүүд, 470 хөхүүл эхчүүд, 5 хүртэлх насны 1,789 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 550 иргэд байжээ. Шуурхай сэргээн босгох арга хэмжээний хүрээнд Онцгой байдлын төвлөрсөн сангаас гамшигт хамгийн хүндээр нэрвэгдсэн 3500 малчин өрхийн гишүүн бүрт 100 ам.долларын буцалтгүй тусламж үзүүлсэн. Энэхүү санаачилгыг хэрэгжүүлэх хүрээнд өрхүүдэд бэлэн мөнгөний тусламжийг хүргэхэд ХААН болон Төрийн банкт хамтран ажилласан.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын газар тариалан, мал аж ахуйн салбар нь ган, зуд болон малын гоц халдварт өвчин дэгдсэнээс болж ихээхэн хямарсан. 2017-2018 оны өвөл, улсын болон орон нутгийн хэмжээнд


өвс хадлан, тэжээлийн нөөцийн хомсдолтой тулгарсан билээ. Эдгээр бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд НҮБ-аас гамшгийн эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зорилгоор хөрөнгө санхүү дайчлах ажлыг системтэйгээр зохион байгуулсан. Ган, зудад нэрвэгдсэн 16 аймгийн 6000 орчим малчин өрх, 13 аймгийн 54 суурь малыг хүндрэлийг даван туулахад нь зориулж малын тэжээл, анхан шатны тусламжийн багцийг нийлүүлсэн. Үүний үр дүнд мал сүргийн хорогдлыг 50 орчим хувиар бууруулсан хэмээн бүртгэгдсэн. Түүнчлэн 6 аймагт хонь, ямааны цэцэг өвчний тархалтыг хязгаарлах зорилгоор яаралтай тусламж үзүүлэв. Мөн 4,0 сая орчим бог малыг цэцэг өвчний дархлаажуулалтад хамруулснаар хүн амын амьжиргааг хамгаалж, 5000 гаруй малчдын хоол хүнс хамгаалагдаж, малчдын бэлэн байдал сайжирсан. НҮБ-аас Шуурхай арга хэмжээ болгон таван сум, нийслэл, аймгийн төвийн 1000 гаруй эмзэг бүлгийн малчин өрхийг өвлийн хатуу ширүүн улирлыг даван гарахад нь туслах, хоол хүнс, тэжээлийнх нь аюулгүй байдлыг хангах зорилгоор мөнгөн тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлсэн.

Байгалийн гамшгийн үед болон дараа нь түргэн шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахын тулд НҮБ-аас Онцгой байдлын ерөнхий газарт (ОБЕГ) дэмжлэг үзүүлж, Нүүлгэн шилжүүлэлтийн матриц (DTM), Гамшгийн бэлэн байдалд хөдөлгөөний хяналт шинжилгээ хийх зэрэг ажлыг хэрэгжүүлсэн. Нүүлгэн шилжүүлэлтийн матриц нь Монгол Улсын хэмжээнд хүн амын хөдөлгөөний талаар ерөнхий ойлголт өгөх зорилготой. Нүүлгэн шилжүүлэлтийн матрицыг гаргахдаа ОБЕГ-ын мэдээллийн санг ашигласан бөгөөд цаашид хүн амын хөдөлгөөний талаарх мэдээллийг илүү системтэйгээр цуглуулах шаардлагатай болохыг тодорхойлсон болно. Хүн амыг нүүлгэн шилжүүлэх байршлуудад шуурхай үнэлгээ хийх, байгалийн гамшигт үзэгдлийн дараа нүүлгэн шилжүүлэлтийн байршлуудад


хяналт тавих, бүртгэх зэрэг ОБЕГ-ын чадавхыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан «Гамшгийн бэлэн байдлыг тодорхойлох гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэлт» сэдэвт үзүүлэх сургуулийн үеэр Кемпийн (Camp) зохицуулалт, Кемпийн менежмент (СССМ), Нүүлгэн шилжүүлэлтийн талаарх мэдээлэл цуглуулах зэрэг хэд хэдэн чадавх бэхжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү үзүүлэх сургууль нь байгалийн гамшиг тохиолдсон үед болон дараа нь түргэн шуурхай,

үр дүнтэй хариу арга хэмжээ авах чиглэлээр талууд хэрхэн хамтран ажиллах, үйл ажиллагаагаа хэрхэн зохицуулах талаарх холбогдох байгууллагуудын ойлголт, ажлын уялдаа холбоог сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд нөхцөл байдалд үнэлгээ хийх, тоо мэдээлэл цуглуулах, боловсруулах, эдгээр мэдээллээ гамшгийн эсрэг авах хариу арга хэмжээний талаар шийдвэр гаргахдаа зөв ашиглаж сурах талаарх үндэстний чадавхыг бэхжүүлж өгсөн.


ЗОРИЛГО 1.4:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 1.4:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 1.4:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 1.4:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

ОБЕГ, ADRA, Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн, Mercy Corps, People in Need, Улаан загалмайн нийгэмлэг

ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 2



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ, ЧАНАРТАЙ, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 ОН ГЭХЭД ЯДУУ БОЛОН ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМ НИЙГМИЙН САЙН ХАМГААЛАЛТААС АШИГ ТУС ХҮРТЭЖ, ЧАНАРТАЙ, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР, ЯЛАНГУЯА, УНДНЫ УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ИЛҮҮТЭЙ ХАНГАГДАНА

Тогтвортой хөгжлийн зорилго болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ыг иш үндэс болгон эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, ундны ус, ариутгал, ариун цэврийн байгууламж, нийгмийн хамгаалал зэрэг чанартай, тэгш хүртээмжтэй нийгмийн үйлчилгээний хангамжийг сайжруулах чиглэлээр НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт үзүүлдэг дэмжлэгээ үргэлжлүүлж байна. НҮБ-ын системийн 9 байгууллага нийтдээ 13.93 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилтийг босгосны 12.48 сая

ам.долларын хөрөнгийг 23 хэрэгжүүлэгч талуудтайгаа хамтран 13 аймаг, нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжүүлж байгаа 25 төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулсан. Нийт зарцуулсан хөрөнгийн 57 орчим хувийг ТХЗ 3– Эрүүл мэндийг дэмжих, ТХЗ 2– Өлсгөлөнг эцэслэх, ТХЗ 5– Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ТХЗ 4– Чанартай боловсролыг дэмжих, ТХЗ 6– Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах зэрэг таван ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан байна.



©НҮБ-ХС

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ГОЛ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2018 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 14.5, 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 27 байна.³ Ундны ус, ариун цэврийн байгууламжийн сайжруулсан үйлчилгээний хүртээмж бага зэрэг ахицтай байна. 2018 оны байдлаар ундны усны сайжруулсан эх үүсвэрт холбогдсон хүн амын хувийн жин 64 хувиас 67 хувь болж нэмэгдсэн бөгөөд, сайжруулсан

ариун цэврийн байгууламжтай холбогдсон хүн амын хувийн жин 2016 оны суурь үзүүлэлт болох 59 хувиас 62 хувь болж өссөн байна. Бага боловсролын сургуульд хамрагдалт 2016 онд 91.4 хувь байсан бол 2017 онд 92.7 хувь болж нэмэгдсэн бөгөөд охидын 93.2 хувь, хөвгүүдийн 91.1 хувь нь бага боловсролын сургуульд тус тус хамрагдсан байна.

ЭРҮҮЛ МЭНД - ТӨРӨЛТИЙН БҮРТГЭЛ

Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, хүн бүрийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулахыг тэргүүлэх чиглэл болгон Хүн амын эрүүл мэндийн талаар Монгол Улсын төрөөс баримтлах бодлого болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан нь Монгол Улсын Засгийн газар болон бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж байна. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд уушгины хатгалгаанаас сэргийлэх вакцин (PCV)-ы дархлаажуулалт, бичил тэжээл, жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг худалдан авах хөрөнгө Монгол Улсын 2019

оны эрүүл мэндийн салбарын төсөвт тусгагдсан. Тоо мэдээллийн олдоц, чанарт ч томоохон ахиц гарсан. Олон жил уйгагүй хийсэн судалгаа шинжилгээний ажил, НҮБ-аас гаргасан зөвлөмж, ЭМЯ, ҮСХ, Иргэний бүртгэлийн газар зэрэг байгууллагуудын нягт хамтын ажиллагааны үр дүнд шинээр төрсөн хүүхдийг төрсөн даруйд нь албан ёсны бүртгэлд хамруулах журам хэрэгжиж эхэлсэн. Энэ нь төрөлтийн бүртгэлийг үнэн бодитой болгож, шинэ төрсөн хүүхэд төрсөн даруйгаасаа нийгмийн хамгаалал авч эхлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ

2018 онд Улаанбаатар хотын агаарын бохирдлын талаарх олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр НҮБ-ын системийн байгууллагууд хамтран ажилласан. Ингэснээр агаарын бохирдлын талаарх бодит мэдээллийг бүрдүүлж, бодлогын арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага зайлшгүй байгааг гаргаж тавих, ялангуяа, хүүхэд, жирэмсэн эхчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа агаарын бохирдлыг

бууруулахад улс төрийн үүрэг хариуцлага хүлээх хэрэгтэй болсныг илэрхийлсэн юм (ТХЗ 3 – Эрүүл мэндийг дэмжих, ТХЗ 7 – Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх). Ийнхүү НҮБ-ын системийн байгууллагуудаас явуулсан сурталчилгаа нөлөөллийн ажлын үр дүнд агаарын бохирдолтой холбоотой асуудлыг Эрүүл мэндийн системийн бэлэн байдлын төлөвлөгөөнд оруулсан.

ХҮНСНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ

Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол тэжээлийн байдлыг сайжруулах зорилгоор хүнсний үйлдвэрлэл, баяжуулалт, чанарын хяналтын механизмыг боловсронгуй болгох чиглэлээр НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлж байна. Энэ хүрээнд Баяжуулсан хүнсний тухай хууль, хүүхдийн

хоол тэжээлийн байдалд хяналт, шалгалт хийх журам, хоол тэжээлийн хүнд хэлбэрийн дутлын үед авах арга хэмжээний талаарх протокол зэргийг боловсруулан батлуулж, хүнсний ногооны салбарын холбогдох хууль, тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд мөн техникийн туслалцаа үзүүлсэн.

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

Хүн амын боловсролыг дэмжих хүрээнд сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролоос эхлүүлэн дээд боловсрол хүртэлх бүх шатны боловсролын түвшинд хэрэгжиж байгаа салбарын төлөвлөлт, бодлого, хөтөлбөрүүдэд ТХЗ 4-ыг тусгахад чиглэсэн үйл ажиллагааг НҮБ-ын зүгээс дэмжин

ажиллаж байна. НҮБ-ын системийн байгууллагууд нь хөгжлийн түншүүдтэйгээ хамтран Боловсролын салбарын бодлогод иж бүрэн үнэлгээ хийж Монгол Улсын Засгийн газраас боловсролын талаар хэрэгжүүлэх бодлогын зөвлөмжийг гаргасан. Энэхүү үнэлгээнд боловсролын

³ ҮСХ, www.1212.mn

үйлчилгээний хүртээмж, тэгш шударга байдал, хамралт, чанар, насан туршийн боловсрол зэрэг Монгол Улсын боловсролын тогтолцоонд хамаарах бүхий л асуудлыг хамруулсан болно. Боловсролын тогтолцоонд илүү бодитой хяналт үнэлгээ хийх зорилго бүхий боловсролын менежментийн мэдээллийн системийг 2017-2018 онд байгуулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. Боловсролын салбарын бодлогод хийсэн үнэлгээний үр дүн, зөвлөмжийг үндэслэн АХБ манлайлж Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA), НҮБ-ын Боловсрол шинжлэх ухаан соёлын байгууллага (НҮБ БШУСБ), НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБ ХС), Дэлхийн банк зэрэг байгууллагуудын оролцоотойгоор Боловсролын салбарын 2020-2030 оны мастер төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлж

ажиллаж байгаа болно. Түүнчлэн ЕБС-ийн багш нарт зориулсан Мэдээллийн технологийн чадавхын үндэстний стандарт боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Техник мэргэжлийн боловсрол, сургалт болон ур чадварын сургалтын талаарх бодлогод үнэлгээ хийж бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан. Боловсролын тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ чанартай, тэгш хүртээмжтэй боловсролыг дэмжих зорилгоор бусад салбарууд, олон нийт, оюутан сурагчид, эцэг эхчүүдтэй нягт хамтран ажиллахыг дэмжиж байна. Түүнчлэн Монгол Улсын дээд боловсролын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, тэдний олгож байгаа мэргэжил мэргэшлийн стандартыг олон улсын түвшинд зөвшөөрөгдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр НҮБ-аас дэмжлэг үзүүлж байна.

УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ


Ундны ус, ариун цэврийн байгууламжийн талаар өнөөгийн баримталж байгаа салбарын бодлого, хууль тогтоомжид ТХЗ-ын үзэл санааг тусгах асуудал нь НҮБ-ын 2017-2018 оны үйл ажиллагааны хөтөлбөрт чухал байр суурийг эзэлж ирсэн. Ундны ус, ариун цэврийн байгууламжийн талаарх салбарын хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн ард иргэд, сургууль, эрүүл мэндийн байгууллагууд зэргийг өөрсдийн хэрэгцээний ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулж, хүн амын бүхий л бүлгүүдийн тусгай хэрэгцээнд нийцсэн

Ундны ус, ариун цэврийн байгууламжийн загвар төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Усны үйлчилгээний үнэ тарифыг тогтоох аргачлалыг сайжруулах нь анхаарал хандуулах бас нэг чухал асуудал байв. Хүн амын бүлгүүдийн, ялангуяа, хүүхэд, залуучуудын онцлог хэрэгцээг хангахад чиглэсэн нотолгоонд суурилсан яриа хэлцэл, шийдвэрийг дэмжих зорилгоор нийгмийн хамгааллын хүрээнд олон хэмжээст ядуурлын талаарх ойлголт мэдлэгийг сайжруулах, үнэн бодитой мэдээлэл бий болгоход анхаарч ажиллаж байна.


ЗОРИЛГО 2:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 2:
НҮБ-ЫН
СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 2:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



Зорилго 2.1

ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ, УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ТЭГШ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ИЛҮҮ ТААТАЙ ОРЧИН БҮРДСЭН, МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААТАЙ, НИЙГМИЙН УХАМСАРААР ДЭМЖИГДСЭН УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ СОНГОГДСОН ХОТЫН ЗАХЫН ХОРООЛОЛ БОЛОН СУМДАД САЙЖРУУЛАХ;



Ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх

Ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний салбарын ерөнхий зохицуулалт болон үндэсний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах бодлогын хүрээнд тус салбарт ЭХЯ-ны гүйцэтгэх үүрэг чадавхыг бэхжүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. НҮБ нь Усны үйлчилгээг зохицуулах үндэсний зөвлөлтэй нягт хамтран ажиллаж, усны үйлчилгээний үнэ тарифыг тогтоох шинэ аргачлалыг нэвтрүүлснээр гэр хорооллын иргэдийн хэрэглээний усны үнэ буурч, иргэд ундны усаа хямд үнээр авч хэрэглэх боломжийг бүрдүүлсэн. Ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор Сургуулиудын түншлэлийн сүлжээг үүсгэн хамтран ажилласнаар цэцэрлэг, сургууль, дотуур байранд үндэсний стандарт хэм хэмжээ, хэрэгцээ шаардлагыг мөрдөн хэрэгжүүлэх Боловсролын салбарын чадавхыг сайжруулсан. Энэхүү сүлжээ нь засгийн газрын холбогдох байгууллагууд, үндэсний болон олон улсын ТББ, хувийн хэвшлийнхэн, хандивлагчид болон бусад түншүүд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Ариун цэврийн аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах үндэсний чадавхыг бэхжүүлэх зорилгоор ЭМЯ, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газартай хамтран хэд хэдэн төслийг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд Нийслэлийн хүн амын усан хангамжийн аюулгүй байдлыг хангах, ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах хөтөлбөрийг хөрөнгө оруулалтын төсвийнх нь хамт нийслэлийн

ИТХ-аар батлуулсан. Ундны усны чанарын стандартыг ус хангамжийн аюулгүй байдлын үүднээс шинэчлэн боловсруулж, 2018 оны 6-р сард батлуулав. Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хоёр аймгийн төвийн усан хангамжийн байгууллагуудын Усны аюулгүй байдлын төлөвлөгөө (WSP)-ний хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шалгалт хийв. Жижиг суурин газруудын, тухайлбал, нийт 33 сумын Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд усны аюулгүй байдлын мэргэжилтнүүд ЭМЯ-тай хамтран хөндлөнгийн үнэлгээ хийсэн. Эдгээр үнэлгээний үр дүнгээс харахад Орон нутгийн түвшинд ундны усны аюулгүй байдлыг сайжруулахын тулд мэдээлэл судалгаанд суурилсан шийдвэр гаргах шаардлагатай байна.

НҮБ-ын Дэлхийн ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ, ундны усны хангамжид хийх дүн шинжилгээ, үнэлгээний аргачлалын дагуу Монгол Улсын онцлогт нийцүүлж ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ, ундны усны хангамжийн талаарх судалгааг олон салбарыг хамруулж 2018 онд явуулсан. Судалгааны тайланг одоогоор эцэслэн боловсруулж байна. Энэхүү судалгаа нь тус улсын Ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт өгч, цаашид тус салбарын засаглал, санхүүжилт, холбогдох салбаруудын хүлээх үүргийг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулсан.

Олон нийтийн оролцоо, хэлэлцүүлэг

Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын бие даасан, өрсөлдөх чадвартай, хүртээмжтэй дэд төвүүдийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын байгууллагуудын иргэдийнхээ оролцоог дэмжих, жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх чадавхыг бэхжүүлсэн.

Нийслэл Улаанбаатар хотын дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөний нарийвчилсан зураг төсөл, төлөвлөгөөг эцэслэн боловсруулсан бөгөөд үүнд гэр хорооллын дэд төвүүдийн нутаг дэвсгэрт баригдах 11.06 км урттай усан хангамжийн сүлжээ, 18.55 км урттай бохир ус дамжуулах


хоолой, дэд төвүүдээс гаднах нутаг дэвсгэрт баригдах 8.6 км урттай бохир ус дамжуулах хоолой барих, Баянхошуу, Сэлбэ орчмын дэд төвүүдэд тус бүрт нь 1000 метр урттай усан сан байгуулах зэрэг төлөвлөгөө орсон бөгөөд эдгээр төслийн талаар тухайн бүтээн байгуулалтын үр шимийг хүртэгчидтэй, тухайлбал, эмэгтэйчүүд, өндөр настанууд,

тусгай хэрэгцээтэй хүмүүс, ойр орчны оршин суугч ард иргэд, өрхийн гишүүдийн төлөөлөлтэй нухацтай хэлэлцэж зөвлөлдсөн болно. Дээрх зураг төсөл төлөвлөгөө болон тэдгээрийг хэрэгжүүлэх арга механизмыг тооцохдоо эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн бусад хүн амын онцлог хэрэгцээг анхаарч ажиллаа.


ЗОРИЛГО 2.1:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 2.1:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 2.1:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 2.1:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

БСШУСЯ, ЭМЯ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Орон нутгийн захиргаад, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, АХБ

Зорилго 2.2

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХИЙН ТУЛД ХОТ СУУРИН, ХОТЫН ЗАХЫН ХОРООЛОЛ БОЛОН ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЯДУУ, ЭМЗЭГ ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ; ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХҮН БҮР ТЭГШ ХАМРАГДАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ; НОТЛОГООНД СУУРИЛСАН БОДЛОГО, ШИЙДВЭР ГАРГАХАД ҮНДЭСНИЙХЭЭ БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХЫГ ДЭМЖИХ;



Тоо мэдээлэл цуглуулах талаарх техникийн туслалцаа

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бүх нийтийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах (Төрөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар баримтлах бодлого 2017) талаар дэвшүүлсэн, ТХЗ-той нийцсэн хэтийн болоод дунд хугацааны эрүүл мэндийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээлэл судалгаатай бодлого шийдвэр гаргахад нь Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас техникийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн. Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх гол зарчим болгон үндэсний болон орон нутгийн аль аль түвшинд хэрэгжүүлэх

бодлого хөтөлбөрийг боловсруулсан. Үүний зэрэгцээ, бодлого, хөтөлбөрийг боловсруулах явцад дэлхийн болон бүс нутгийн сайн мэдлэг, туршлагаас суралцахыг дэмжиж, хэлэлцүүлэг, зөвшилцлийн механизмыг гол стратеги болгож байсан. Эх, хүүхдийн эрүүл мэнд, БЗХ/ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд зэрэг хөтөлбөр бүрийн хүрээнд хийсэн олон тооны өргөн хүрээний судалгаа шинжилгээ, үнэлгээ, тайлан мэдээллийг бодит нотолгоо болгон ашигласан бөгөөд эдгээр нь шийдвэр гаргах түвшинд үнэтэй хувь нэмэр оруулна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамралт

Монгол Улсын Засгийн газар 2019 онд уушгины хатгалгаанаас сэргийлэх вакцин (PCV)-ы дархлаажуулалтыг өргөжүүлэх, бичил тэжээл, жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хангамжийг улсын хэмжээнд сайжруулах (засгийн газрын санхүүжилттэй төсвийн хөрөнгөөр) талаар тодорхой шийдвэр гаргасан. Олон жил уйгагүй хийсэн судалгаа шинжилгээний ажлууд, НҮБ-аас гаргасан зөвлөмж, ЭМЯ, ҮСХ, Иргэний бүртгэлийн газарг зэрэг байгууллагуудын нягт хамтын ажиллагаа зэргийн үр дүнд шинээр төрсөн хүүхдийг төрсөн даруйд нь албан ёсны бүртгэлд авах журам хэрэгжиж эхэлсэн нь төрөлтийн бүртгэлийг үнэн бодитой болгож, шинэ төрсөн хүүхэд төрсөн даруйгаасаа нийгмийн хамгаалал авч эхлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн. ТХЗ-ыг дэлхий даяар хэрэгжүүлж буй өнөө үед олон салбарын нягт хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх замаар сүрьеэ өвчнийг таслан зогсоох тухай Улаанбаатарын тунхаглалыг гаргасан нь 2017-2018 онуудад гаргасан томоохон амжилтуудын нэг болсон.


Саяхан боловсруулсан Хүн амын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх хөгжлийн дунд хугацааны салбар дундын төлөвлөгөө боловсруулах зорилгоор орон нутгийн эрүүл мэндийн бүх байгууллагуудад зориулсан «хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх» зарчмыг баримтлах талаар сургалт зохион байгуулсан. Нийт аймгууд төлөвлөгөөгөө




боловсруулж, хэрэгжүүлж эхлээд байна. Орон нутгийн эрүүл мэндийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулах чадавх (IHR) бүрдүүлэх, бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах (UHC), бүх талуудын идэвхтэй оролцоог дэмжих замаар ард иргэд олон нийтийн оролцоог онцгойлон дэмжих зэрэг хүн рүү төвлөрсөн арга зарчмыг баримталж ажиллаж байна.

Эх, хүүхдийн эрүүл мэнд, БЗХ/ХДХВ-ын халдвараас урьдчилан сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, түүнчлэн радио-иммуно-ассей технологи, цацрагийн эмчилгээний чанартай үйлчилгээ үзүүлэх зэрэг чиглэлээр орчин үеийн, шинэлэг арга технологийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байна.


ЗОРИЛГО 2.2:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 2.2:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 2.2:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 2.2:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

Монгол Улсын Их хурал, СЯ, ХНХЯ, ЭМЯ, Орон нутгийн захиргаад, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүний эрхийн үндэсний зөвлөл, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын төв нэгдүгээр эмнэлэгийн Цөмийн оношлогооны тасаг, Монгол Улсын Шинэ нийгмийн эрүүл мэндийн холбоо, Монголын хүүхдийн эмч нарын холбоо, АШУУИС.

Зорилго 2.3

ИЛҮҮ ЧАНАРТАЙ СУУРЬ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИЖ, ХҮҮХДИЙГ БАГА НАСНААС НЬ ХӨГЖҮҮЛЭХ, УЛМААР НАСАН ТУРШ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨРИЙГ ХОТЫН ЗАХЫН ХОРООЛЛЫН СОНГОГДСОН ХЭСГҮҮД, ЗАРИМ СУМДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ;



Үндэсний чадавхыг бэхжүүлэх

Боловсролын салбарын бүх түвшний холбогдох талуудын (бодлого шийдвэр гаргагчдаас эхлүүлэн сургуулийн багш нарыг оролцуулан) чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цуврал сургалт, семинарыг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээний хүрээнд ТХЗ-ын талаарх үндэсний хэлэлцүүлгүүд, боловсролын талаарх тоо мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах сургалтууд, салбарын бодлого, төлөвлөлтөд бодлогын шинжилгээ хийх семинарууд, боловсрол, сургалтад мэдээлэл технологийг нэвтрүүлэх чиглэлээр багш нарын чадавхыг дээшлүүлэх сургалт семинаруудыг зохион байгуулсан болно.

Боловсролын чанар, агуулга, шударга байдал, хүртээмж, Боловсролын талаар баримталж байгаа бодлого, Салбарын хэмжээний төлөвлөлт зэрэг боловсролын салбарын үндсэн гурван хүрээг хамарсан Боловсролын салбарын бодлогын үнэлгээг 2018 онд эхлүүлсэн. Энэхүү үнэлгээний үр дүн, зөвлөмжийг ESMP 2020-2030 хөтөлбөрт тусгах болно. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын мэдээллийн технологийн цогц чадамжийн үндэсний стандартыг боловсруулж, одоогоор МСҮТ болон ур чадварын сургалтын талаарх бодлогын шинжилгээг хийж байна.

Хүүхдийг бага наснаас нь хөгжүүлэх


Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, эмзэг бүлгийн хүүхдүүд, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд тэгш, чанартай боловсролын цогц үйлчилгээ хүргэх нөхцөлийг сайжруулах чиглэлээр НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлж байна. Үүний үрдүнд салбар хоорондын хамтын ажиллагааг хангах зорилготой Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц үйлчилгээний нэгдсэн стратеги төлөвлөгөөг боловсруулан орон нутгийн хороодоор баталж, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих өөр нэг хувилбар болгон ундны ус, ариун

цэврийн зохистой нөхцөлийг бүрдүүлсэн Гэр цэцэрлэгийг байгуулж УБ хот болон хөдөө орон нутагт амжилттай туршин хэрэгжүүлж байна. Хүүхэд бүр тэгш хүртээмжтэй боловсролын үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг ердийн сургуульд тэгш хамруулж нийгэмшүүлэхийг дэмжих зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг хүртээмжтэй боловсролын үйлчилгээ үзүүлэх загвар болгон 3 аймагт байгуулсан.


ЗОРИЛГО 2.3:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 2.3:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 2.3:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 2.3:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

БСШУСЯ, АХБ

Зорилго 2.4

НИЙТ ХҮН АМЫГ, ЯЛАНГУЯА, ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМЫГ ТҮЛХҮҮ ХАМРУУЛСАН ҮР АШИГТАЙ, ҮР НӨЛӨӨТЭЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ,



Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх

Монгол Улс дахь НҮБ нь тус улсын нийгмийн хамгааллын бодлого, ажилчдын аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй, тэгш хүртээмжтэй, шударга нийгмийн хамгааллын тогтолцоог хөгжүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн үндэсний болон орон нутгийн байгууллагуудын чадавх, мэдлэг мэдээллийг сайжруулах чиглэлээр дэмжин ажиллаж байна. Энэхүү хүчин чармайлтын үр дүнд ядуурлыг бууруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх талаарх өргөн хүрээний яриа хэлэлцүүлэг өрнүүлж орон нутгийн удирдлагуудын дуу хоолойг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) болон үндэсний түвшний шийдвэр гаргагчдад хүргэх нөхцөл бүрдсэн. Нөлөөлөл сурталчилгааны үйл ажиллагааны хүрээнд, “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гарсан сургамж, бодит жишээнд тулгуурлан нийгмийн хамгааллын мөн чанар, хүн амын бүлгүүдийн хамгааллын гадна орхигдох эрсдэл, ялгаварлал, хүн амын орлогын аюулгүй байдал, хүний эрх зэрэг асуудлын талаарх мэдээллийг бодлого боловсруулагчдад хүргэсэн болно. Нийгмийн хамгааллын хөтөлбөрт гарах өөрчлөлтөөс үүдэж хүүхэд болон орон


нутгийн ард иргэдийн амьжиргаанд үзүүлэх нийгэм, эдийн засгийн үр нөлөөнд хяналт шинжилгээ хийх зорилгоор Монголын Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)-тэй хамтран Нийгмийн халамжийн зардлын өөрчлөлтийн үр нөлөөний нөхцөл байдлын талаар судалгаа хийсэн. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад урьдчилан сайн тооцоолж, цаг тухайд нь хүргэж байх аваас хүүхэд болон тэдний гэр бүлд халамжийн тэтгэмж, бэлэн мөнгөний тусламж үр нөлөөтэй байжээ. Үүнээс гадна сар бүр бэлэн мөнгөний тусламж олгох нь хүүхэдтэй гэр бүлүүд шим тэжээлтэй хоол хүнсээ авах маш чухал орлогын эх үүсвэрийн нэг болж байна.

НҮБ-аас хийсэн үнэлгээний үр дүн, зөвлөмжид үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаарх урьдчилан сэргийлэх арга хэмжээ, аливаа шийдвэрийг хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт (засгийн газар, ажил олгогч, ажилчид) хэлэлцээрээр гаргаж байх талаар 2017 оны Наймдугаар сард батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр (2017-2018)-т тусгагдсан болно.


ЗОРИЛГО 2.4:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 2.4:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 2.4:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 2.4:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

ХНХЯ, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо,
Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо

Зорилго 2.5

ХҮНС БОЛОН ХООЛ ТЭЖЭЭЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ (ЭРҮҮЛ ХҮНС/ТЭЖЭЭЛИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ, ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ДУТЛЫН ЭРСДЛИЙГ ЭРС БУУРУУЛАХ, ХҮНС, ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ТАНДАН СУДАЛГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ)



Хүнсний чанарыг сайжруулах

Энэхүү үр дүнгийн хүрээнд хүнсний аюулгүй болон баталгаатай байдлыг хангах, хүн амын хамгийн эмзэг бүлгийн нэг болох хүүхдийн хоол тэжээлийн асуудлыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Хүнсний үйлдвэрлэлийн тухайд, хүнсний ногооны салбарын эрх зүйн орчныг сайжруулахад НҮБ-аас дэмжлэг үзүүлсээр байна. Таримал ургамлын үр, сортыг хамгаалах олон улсын конвенц (UPOV конвенц)-т нийцүүлэн Таримал ургамлын үр, сортыг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн төслийг Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэлийн талаарх зургаан төрлийн журам, хүнс, хөдөө аж ахуйн салбарт мөрдөх хорин найман стандарт, хүнсний ногооны дэд салбарын Газар тариалангийн сайн туршлага зэрэг баримт бичгүүдийн хамт боловсруулсан. Ингэснээр

улсын байцаагчид, агрономичдын чадавхыг ихээхэн нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан. Хил дамнансан малын өвчний оношлогоо, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үндэсний чадавх ч бэхжсэн. Лабораторийн тоног төхөөрөмж, тухайлбал, оношлогооны иж бүрдэл, урвалж, хээрийн тоног төхөөрөмж суурилуулж, оношилгооны шинэ шинэ аргыг нэвтрүүлсэн. Түүнчлэн хэрэглэгчдийн аюулгүй байдлыг сайжруулах, Монгол Улсын малын гаралтай бүтээгдэхүүний экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор цөмийн технологийг ашиглан мал эмнэлэгийн товлот үзлэг, малын эмийн хэрэглээ, бохирдуулагч бодист системтэй хяналт шинжилгээ хийх үндэсний эрдэм шинжилгээний чадавхыг бэхжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлж байна.

Илүү сайн хоол тэжээл

Хүүхдийн хоол тэжээлийн төлөв байдлыг сайжруулахын тулд 2018 оны 5-р сард Монгол Улсын Их хурлаар Баяжуулсан хүнсний тухай хуулийг баталж тус улсад өндөр түвшинд байгаа бичил тэжээлийн дутлыг шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлж өгсөн. Энэ үйл явцад НҮБ-аас нөлөөлөл сурталчилгааны болон техникийн туслалцаа үзүүлсэн. Баяжуулсан хүнсний тухай хуулиар Монгол Улсад үйлдвэрлэж байгаа болон импортолж байгаа гурилыг заавал бичил тэжээлээр баяжуулж байхыг журамласан. НҮБ болон Азийн хөгжлийн банк (АХБ) хамтран нөлөөлөл сурталчилгааны үйл ажиллагаа явуулсны үр дүнд 6-23 сартай хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд нэн шаардлагатай нэмэлт тэжээл олгох тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж СЯ-наас 2019 оны улсын төсөвт 1.4 тэрбум (550,000 ам.доллар орчим) төгрөгийн хөрөнгийг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний багцийн нэг хэсэг болгон хуваарилсан. Түүнчлэн 2017 онд батлагдсан хүүхдийн хоол тэжээлийн бүтээгдэхүүнийг

сурталчлах, хүнсний бүтээгдэхүүний шошгожилт, нийтийн эзэмшлийн болон жижиглэн худалдааны цэгүүд, эрүүл мэндийн байгууллагууд дээр зөвшөөрөлгүйгээр хүүхдийн хоол тэжээлийн бүтээгдэхүүний талаар элдэв сурталчилгаа явуулах зэрэгт хяналт тавихыг зүйлчилсэн. Нярайн болон хүүхдийн хоол тэжээлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүний үр дүнд хяналт шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт техникийн туслалцаа үзүүлж байна. Тэжээлийн архаг дутлын цогц менежментийн үндэсний протоколыг боловсруулах, үндэсний чадавхыг бэхжүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсний үр дүнд тэжээлийн хүнд хэлбэрийн архаг дутлын менежмент илүү сайжирч байна. Хоол тэжээлийн архаг дутлын менежментийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 0-2 насны 19,300 хүүхэд, 5,600 жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд хамрагдсан. Төсөлд хамрагдсан газруудын тэжээлийн хүнд хэлбэрийн архаг дуталтай 57 хүүхэд 2018 онд амь


насыг нь аврах эмчилгээнд хамрагдсан бөгөөд тэдний 88 хувь нь илааршиж эмчлэгдсэн. Үүний зэрэгцээ эхчүүд болон нярай хүүхдүүдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг газруудад зориулан хүүхдээ хөхөөр тэжээхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилго агуулсан Хүүхдэд ээлтэй эмнэлэг санаачлага (BFHI)-ын удирдамжийг шинэчилсэн нь үр дүнгээ өгч байна. НҮБ-ын тусламжийн хүрээнд хэрэгжүүлсэн мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны

дүнгээс харахад хүүхдүүдийн дунд илүүдэл жин, таргалалт нэмэгдэж байгаа нь хүүхэд болон насанд хүрэгчдийн эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй байна. НҮБ-аас өгсөн зөвлөмжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь элсэн чихэр болон бусад нэмэлт бодис агуулсан импортын бүтээгдэхүүний татварыг 20 хувиар нэмэгдүүлэх талаар албан ёсны хүсэлтээ гаалийн үнэ тариф тогтоох хороонд хүргүүлсэн.


ЗОРИЛГО 2.5:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 2.5:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 2.5:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 2.5:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

ХХААХҮЯ, БСШУСЯ, ЭМЯ, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Ургамал, газар тариалангийн шинжлэх ухааны хүрээлэн, Мал эмнэлэгийн хүрээлэн, Хөдөө аж ахуйн их сургууль

ҮР ДҮНГИЙН ЧИГЛЭЛ 3



ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИЖ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ



ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ:

2021 ОН ГЭХЭД ЗАСАГЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД НЬ ЗАЛУУЧУУДЫН ИДЭВХТЭЙ ОРОЛЦООГ ДЭМЖИЖ, ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙНХНИЙ БОЛОН ХҮН БҮРИЙН ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛЖ АРД ИРГЭДИЙНХЭЭ ӨМНӨ ИЛҮҮ НЭЭЛТТЭЙ БАЙЖ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГАА ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙНА

Энэхүү үр дүнгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гол зорилго нь “хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх”, улс орны хөгжлийн үр шим хүн бүрт, ялангуяа, залуучууд, ядуу, эмзэг бүлгийн хүн амд өгөөжтэй байх нөхцөлийг хангах үүрэг бүхий засаглалын байгууллагуудын чадавхыг сайжруулахад чиглэгдсэн. Энэ хүрээнд НҮБ-ын системийн 7 байгууллага нийтдээ 15.45 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилтийг босгосон бөгөөд үүнээс 8.6 сая

ам.долларын хөрөнгийг хэрэгжүүлэгч 21 байгууллагатай хамтран 8 аймаг, нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн 17 төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулсан. Нийт хөрөнгийн зарцуулалтын дийлэнх хувийг ТХЗ 16– Энхтайван, шударга ёсыг цогцлоох, ТХЗ 5– Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ТХЗ 3– Эрүүл мэндийг дэмжих, ТХЗ 17– Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэг дөрвөн ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан болно.



©ДЭМБ

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛЛЫН МЕХАНИЗМ

Сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар, НҮБ хамтран тус улсын хууль эрх зүйн хамгааллын механизмыг боловсронгуй болгох чиглэлээр томоохон алхам хийсэн. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Залуучуудын хөгжлийн тухай хуулийг боловсруулж баталлаа. Түүнчлэн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэг хуулиудын шинэчилсэн найруулгыг боловсруулж батлуулах ажилд техникийн туслалцаа үзүүлээ. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж УИХ-д өргөн барьсан. Түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг

хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан болно. 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэхэд ХНХЯ, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо зэрэгт НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж 2018 оны 4-р сард Монгол Улсын Их хуралд хэлэлцүүлж батлуулахаар өргөн бариад байна. Хуулийн төслийг боловсруулахдаа зах зээлийн хөгжлийн хандлагад суурилж, ажлын байран дахь хүний эрхийн үндсэн зарчимд илүү сайн нийцүүлсний зэрэгцээ, албан бус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг хамруулж хүрээг нь тэлсэн.

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

Үндэсний хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг НҮБ-аас дэмжиж ажиллалаа. Тухайлбал, 2012 онд батлагдсан Монгол Улсын Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. НҮБ-аас Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажилласнаар Засгийн газрын санхүүжилттэйгээр

Залуучуудын хөгжлийн 16 төвийг 2016 онд байгуулж байсан бол энэ нь 2018 онд 33 болж 2 дахин нэмэгдлээ. Эдгээр төвүүдэд залуучуудын чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн амьдрах ухаан, бэлгийн болон нөхөн үржихүйн боловсрол мэдлэг олгох зэрэг олон төрлийн сургалт, үйл ажиллагааг явуулж байна.

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААГ ХӨГЖҮҮЛЭХ

Тоо мэдээлэл, судалгааг хөгжүүлэх нь 2017/2018 оны үйл ажиллагааны нэг гол чиглэл байв. ҮСХ-оос Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС-SISS)-г 2018 онд Олон үзүүлэлтүүдийн бүлгийн түүвэр судалгаа (MICS)-ны Олон улсын 6 дахь хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. НҮТС нь ТХЗ-ын суурь үзүүлэлтүүдийг тодорхойлоход үнэтэй хувь нэмэр оруулсан. Энэхүү судалгааны үр дүнд нийтдээ 178 хөгжлийн үзүүлэлтийг тооцсоны 31 нь ТХЗ-ын үзүүлэлтүүд байгаа бөгөөд тэдгээрийг үндэслэн бүс нутаг, аймаг орон нутаг, өрхийн амьжиргааны түвшин, боловсрол, хүйс, хөгжлийн бэрхшээлийн байдал болон бусад олон шинжийг үндэслэн нарийвчилсан задаргаатай дүн шинжилгээ хийх боломжтой.

НҮБ-аас Завхан, Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран өсвөр насныхан, залуучуудын дунд сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар судалгаа явуулсан. Түүнчлэн 2018 онд тус улсын хүн амын дунд жендэрт суурилсан хүчирхийллийн бодит байдлыг судлах зорилгоор ҮСХ-той хамтран Жендэрт суурилсан хүчирхийлэл (GBV) -ийн үндэсний хэмжээний анхдугаар судалгааг явуулж, үр дүнг хэвлэн нийтэлсэн.


2017 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК)-оос НҮБ, Европын Холбоотой хамтран Монгол Улсад худалдаа, үйлчилгээ, ноос, ноолуурын үйлдвэрлэл эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэрүүдэд хүний хөдөлмөрлөх эрх хэрхэн хэрэгжиж байгаад судалгаа хийсэн.⁴ Судалгааны үр дүн, зөвлөмжийг ХЭҮК-ын Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх 16 дугаар тайланд тусгаж, УИХ-д өргөн барьсан.




©НҮБ ХАС

⁴ <https://bit.ly/2LcSAqR>


ЗОРИЛГО 3:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 3:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 3:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР





Зорилго 3.1

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ЯЛАНГУЯА, ЯДУУ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМЫГ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС ХАМГААЛАХ ЗОРИЛГООР ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙЖ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ХӨГЖҮҮЛЭХ ЗАМААР ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛЛЫН МЕХАНИЗМЫГ САЙЖРУУЛАХ



Энэхүү үр дүнгийн хүрээнд ядуу, эмзэг бүлгийн хүн амын оролцоог дэмжих, засгийн газрын хариуцлагыг бэхжүүлэх хууль эрх зүйн хамгааллын механизмыг боловсронгуй болгох зорилго тавьсан болно. Тайлангийн хугацаанд НҮБ-аас хүүхдийн хамгааллын орчныг бэхжүүлэхэд чиглэсэн нөлөөлөл сурталчилгааны үйл ажиллагааг үргэлжлүүлж,

салбар хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээнд зориулсан төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалж байгаа эсэхийг таних, лавлах системийг бэхжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэв.

Төрийн албыг бэхжүүлэх

Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаагаараа дамжуулан ядуу, эмзэг бүлгийн хүн амын хууль эрх зүйн хамгаалалтыг хангахын тулд НҮБ-аас төрийн албаны хариуцлагыг бэхжүүлэхэд чиглэсэн олон алхам хийсэн. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад иргэд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, нөлөөллийг хянах шинэ механизмыг нэвтрүүлсэн. Түүнчлэн мэргэжлийн, иргэн төвтэй төрийн үйлчилгээ үзүүлэх ур чадвар, чадавхыг төрийн албан хаагчдад эзэмшүүлэх зорилгоор нийт төрийн албан хаагчдад зориулан явуулдаг сургалтын хэвшсэн механизмд шинэчлэл хийх, улмаар хөгжүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн.

Тайлангийн хугацаанд орон нутгийн засаглалд нөлөөлж буй үндсэн хууль, бусад эрх зүйн шинэчлэлийн талаарх хэлэлцүүлгүүдийг зохион байгуулахад НҮБ-аас дэмжлэг үзүүлсний нэг жишээ бол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг үндсээр нь

шинэчлэх эх суурийг тавьсан явдал юм. Чадавх бэхжүүлэх олон үйл ажиллагаа хэрэгжүүлсний үр дүнд аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нарын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, тухайлбал, төлөөлөл болох, хяналт тавих, зохицуулалт хийх чадвар нь сайжирсан.



©НҮБ XX

Хүн худалдаалахтай тэмцэх

НҮБ нь Монгол Улсын Засгийн газартай хамтран хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны үр нөлөөг олон улсын жишигт нийцүүлэн бэхжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд 2012 онд батлагдсан Монгол Улсын Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх,

улмаар эрэн сурвалжлах, мөрдөн байцаах ажиллагаа, хохирогчдод дэмжлэг үзүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгмийнхний явуулж байгаа үйл ажиллагааг дэмжих, чадавхыг нь бэхжүүлэх талаар анхаарч байна. НҮБ-аас хүн худалдаалахтай тэмцэх


тухай хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийсэн. Түүнчлэн, хохирогчийг танин мэдэх талаархи удирдамж, хөдөлмөрийн байцаагч нарт зориулсан сургалтын

хөтөлбөр, уул уурхайн компаниудын ачааны машины жолооч нарт туслах удирдамж боловсруулах зэрэгт дэмжлэг үзүүлсэн.


ЗОРИЛГО 3.1:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 3.1:
НҮБ-ЫН СИСТЕМ ИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 3.1:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 3.1:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

Монгол Улсын Их хурал, ХЗДХЯ, ХНХЯ, ЭМЯ, Төрийн албан зөвлөл, ҮСХ, Хүний эрхийн үндэсний хороо, Жендэрийн үндэсний хороо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Жендэрийн тэгш байдлын төв, Хүүхдийн биеийг үнэлэх, худалдаалахтэй тэмцэх ТББ, Азийн сан, Монголын Банкуудын холбоо, АХБ



Зорилго 3.2

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮД, ЗАЛУУЧУУДЫН (34 ХҮРТЭЛХ НАСНЫ) ТӨЛӨӨЛЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТУХАЙЛБАЛ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ, ЯАМДЫН САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ИРГЭДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТҮВШИНД



Эмэгтэйчүүдийн төлөөлөл

Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн алба байгуулахад дэмжлэг үзүүлж төрийн албаны удирдах дээд албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд НҮБ-аас зохих хувь нэмрээ оруулж байна. НҮБ-аас Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх хэд хэдэн журмыг боловсруулах, батлуулах үйл явцад дэмжлэг үзүүлсэн. Ийнхүү НҮБ-ын зүгээс хүн бүрт, тэр дундаа эмэгтэйчүүд, эмээг бүлгийнхэнд төрийн албанд элсэх шалгалт өгөх, албан тушаал дэвших, Төрийн албаны зөвлөлийн удирдах албан тушаалд өрсөлдөх, Төрийн хяналтын зөвлөлд хандах зэрэг тэгш шударга, ээлтэй боломж нөхцөлийг бүрдүүлэх

механизмыг бий болгоход дэмжлэг үзүүлж байна. Эдгээр журам нь төрийн захиргааны байгууллага дахь жендерийн эрх тэгш байдлыг сайжруулах зорилготой. Түүнчлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл хамтарсан тогтоол гаргаж нийт төрийн албан хаагчдыг ажлын байран дахь дарамт шахалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаарх сургалтад нийт албан хаагчид заавал хамрагддаг байх журам тогтоохыг НҮБ-ын зүгээс дэмжихийн зэрэгцээ эмэгтэй төрийн албан хаагчдын ажлын байран дахь аюулгүй байдлыг хангах талаар олон алхамууд хийж байна.

Орон нутгийн иргэдийн хурлын хүчирхэг төлөөлөл

Тайлангийн хугацаанд орон нутгийн иргэдийн хурлын төлөөллийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн зорилтот үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлсэн. Тухайлбал, сонгуультай 2000 гаруй эмэгтэй төлөөлөгчдийг Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтанд хамруулан эрх мэдэлжүүлж, тэдэнд улс төрийн шийдвэр гаргахад илүү үр дүнтэй оролцох боломжийг олгов. Сургалтын явцад тэдний төрөл бүрийн үүсгэл санаачилгыг удирдан чиглүүлэх, үзэл санаа нэгтэй хэсэгтэйгээ хамтран лобби бүлэг байгуулах, иргэдтэй үр дүнтэй харилцах зэргээр орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үр чадвар, өөртөө итгэх итгэл нь сайжирсан. Эдгээр санаачлагын заримаас дурдвал, нийтийн аж ахуйн газруудын үйлчилгээнд хяналт тавих, төрийн байгууллагуудын шийдвэрийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор мэдээлэл солилцох уулзалтууд зохион байгуулах, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг орон нутгийн зөвлөлөөр батлуулахад чиглэсэн нөлөөлөл

сурталчилгааны олон ажил хийсэн. Орон нутгийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн хурлын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд илүү итгэлтэй, нөлөөтэй болж байгаа талаар хөндлөнгийн үнэлгээний тайланд дурдсан байна. Түүнчлэн Эмэгтэйчүүдийн манлайллын сургалт нь янз бүрийн түвшинд эмэгтэйчүүд өөр хоорондоо холбоо сүлжээ үүсгэж ажиллахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч намчирхах хэлбэрээр бүлэглэн нэгдэж байгааг анхаарах шаардлагатайг мөн тэмдэглэсэн байна. Нийслэлийн гэр хорооллын дэд төвүүдийг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулж, хүртээмжтэй, хариуцлагатай хотыг хөгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын захиргаанд НҮБ-аас техникийн туслалцаа үзүүлсэн. Үүний үр дүнд орон нутгийн засаг захиргааны шийдвэр гаргах, төлөвлөх, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангах зорилгоор хүн амынх нь 56.3 хувийг нь эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа найман хороо, 66.1 хувийг нь эмэгтэйчүүд бүрдүүлж


байгаа нэг дэд төвд Орон нутгийн иргэдэд түшиглэсэн байгууллагыг байгуулсан. Энэ байгууллага нь эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тухайн дэд

төвийн орон нутгийн бизнес эрхлэгчдийн онцлог хэрэгцээг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байна.


ЗОРИЛГО 3.2:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 3.2:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 3.2:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 3.2:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

Монгол Улсын Их хурал, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэстний хороо, АХБ



Зорилго 3.3

Залуучуудын холбоо, байгууллагуудыг бэхжүүлэх, тэдний санаа бодлоо эрх тэгш түншийн хувьд чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих



Залуучуудын хөгжлийн төвүүд

Монгол Улсын түүхэнд анх удаа залуучуудын асуудлаар тусгайлан хууль батлагдсан нь чухал ач холбогдолтой болсон. Энэхүү Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг боловсруулж батлуулахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, залуучуудын манлайлдаг ТББ-ууд, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо зэрэг байгууллагууд идэвхтэй хүчин чармайлт гаргасан. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд улс орон даяар Залуучуудын хөгжлийн төв (YDC) байгуулах санаачилга гаргасны үр дүнд Засгийн газрын санхүүжилттэйгээр Залуучуудын хөгжлийн 16 төвийг 2016 онд байгуулсан бол, 2018 онд 33 төв болж хоёр дахин нэмэгдсэн. Нийт 21 аймаг, 9 дүүрэг, 2 суманд байгуулагдсан эдгээр Залуучуудын хөгжлийн төвд

залуучуудыг эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн амьдрах ухааны сургалт, бэлгийн болон нөхөн үржихүйн зөвлөгөө өгөх зэрэг олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Түүнчлэн Залуучуудын хөгжлийн төвүүдийг түшиглэн залуучуудын оролцоог хангах, тэднийг эрх мэдэлжүүлэх зорилгоор орон нутгийн салбар зөвлөлүүд, зөвлөх багууд/панел, сонирхлын клубүүд, дэмжих бүлгүүд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. 2018 оны эцсийн байдлаар 21 аймаг, 8 дүүрэг, 155 сум, 21 багт Засаг дарга нараар ахлуулсан 205 орон нутгийн салбар зөвлөл, 43 залуучуудын зөвлөх баг/панел, 231 сонирхлын клуб, 112 дэмжих бүлэг тогтмол үйл ажиллагаа явуулж байна. 2018 онд Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйлчилгээнд нийт 65,636 (15-34 насны) залуучууд хамрагдаж, 831 гэр бүл, залуу хосууд гэр бүлийн асуудлаар зөвлөгөө авч, дэмжих бүлгийн үйл ажиллагаанд 419 залуус хамрагдсан байна.

Залуучуудын чуулган

Залуучуудын асуудлаарх мэдээлэл судалгаанд суурилсан бодлого, хөтөлбөр, залуучуудын хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр 2016 онд ганцхан удаа үндэсний хэмжээний нөлөөлөл сурталчилгааны ажил/платформ хийгдэж байсан бол 2018 онд 3 удаа (Залуучуудын хөгжлийн асуудлаарх Үндэсний чуулган, Залуучуудын хөгжлийн талаарх гурван талт хэлэлцүүлэг, Залуучуудын Панел) хийсэн. Олон улсын залуучуудын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, залуучуудын хөгжил, оролцоог сурталчлах кампанит ажлыг ХНХЯ-аас зохион байгуулсан. Залуучуудын дунд туршлага солилцох зорилгоор Залуучуудын хөгжлийн "Know How" сэдвээр Залуучуудын хөгжлийн дөрөвдүгээр чуулганыг зохион байгууллаа.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн талаар ХЭҮК-ын тайланд тэмдэглэснээс харахад эмэгтэйчүүд, залуучуудын хөдөлмөрлөх эрх ихээхэн хэмжээгээр зөрчигдөж байна. Залуучуудын дунд хөдөлмөрлөх эрхийн талаар сурталчлах зорилгоор Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээ байгуулагдсан бөгөөд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын гол нөхцөл болсон хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийг үл тэвчих, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг дэмжих, ялгаварлан гадуурхалгүй байх зэрэг хүний хөдөлмөрлөх эрх хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих хяналтын хуудсыг ажил олгогчид боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол дахь Загвар НҮБ-ын үйл ажиллагаа

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн Загвар чуулганыг 2 удаа 2017, 2018 онуудад зохион байгуулав. Эдгээр Загвар уулзалтууд нь ахлах сургууль, их сургуулийн оюутнуудын чадавхыг дээшлүүлэх чухал үйл ажиллагаа болсон юм. Загвар НҮБ-ын уулзалтуудаар Дэлхийн иргэний боловсрол (ТХЗ 4); Хөгжлийн төлөөх бүтээлч байдал, соёл (ТХЗ 11, ТХЗ 16); Жендэрт суурилсан хүчирхийллээс

урьдчилан сэргийлэх, таслан зогсоох (ТХЗ 5, ТХЗ 16) зэрэг асуудлаар тогтоолын төсөл гаргаж, оюутан төлөөлөгчдөөрөө хэлэлцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулан, санал хураалт явуулан баталсан. Эдгээр уулзалтууд нь олон талын мэдээллийг харилцан солилцох, хувь хүний болон хэсэг бүлгийн чадавхыг дээшлүүлэхэд үнэтэй боломж олгосон.

Өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах


Тайлангийн хугацаанд Завхан, Говь-Алтай аймгуудад өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэнд, амьдрах ухааныг сайжруулах чиглэлээр төрөл бүрийн шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тухайлбал, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, цуврал хэлэлцүүлгүүд зохион байгуулах зэргээр олон салбарыг хамруулсан арга хэмжээ зохион байгуулсны үр дүнд өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих Аймгийн үйл ажиллагааны гурван жилийн төлөвлөгөө боловсруулсан. НҮБ-ын зүгээс өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, асуудлыг эрт илрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл лавлагаа өгөх зэрэгт чиглэсэн эрүүл мэндийн болон боловсролын анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх 25 мэргэжилтний чадавхыг сайжруулах замаар дээр дурдсан өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Орон нутгийн засаг захиргаад ч мөн хэвтэн эмчлүүлж

буй хүүхдүүдэд зориулсан тусгай өрөөнүүдийг бий болгох зорилгоор аймгийн эмнэлгүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн хэсгийн өргөтгөл, шинэчлэлтийг хийхэд хөрөнгө оруулж энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж байна. Завхан аймагт өсвөр насныханд зориулсан «Миний гэр бүл», «Миний ертөнц» гэсэн хүүхдийн насны онцлогт тохирсон амьдрах ухааны талаарх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж 9366 өсвөр насныхныг хамруулсан нь залууст хүрч ажиллах шинэлэг арга болсон. Энэхүү санаачилгыг Өмнөговь, Говь-Алтай аймгууд дэмжин хэрэгжүүлсэн. Завхан аймгийн өсвөр насныханд зориулсан амьдрах ухааны сургалтуудад хөрөнгө оруулснаар өсвөр насныхны амьдралын ухаанд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг ойлгоход тус болсны зэрэгцээ бодлого шийдвэр гаргагчдад өсвөр насныхандаа хэрхэн хүрч ажиллах, баруун аймгуудад хүргэж байгаа нийгмийн үйлчилгээг өсвөр насныхан хэрхэн хүлээн авч байгаа талаар бодитой мэдээлэл, сургамж авах бололцоог нээж өгсөн юм.


ЗОРИЛГО 3.3:
ХЭРЭГЖҮҮЛСЭН
ГАЗАР НУТАГ



ЗОРИЛГО 3.3:
НҮБ-ЫН СИСТЕМИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАРЦУУЛАЛТ,
2017-2018



ЗОРИЛГО 3.3:
НИЙТ БОСГОСОН
ХӨРӨНГӨ,
САНХҮҮЖИЛТИЙН
ЭХ ҮҮСВЭРЭЭР



ЗОРИЛГО 3.3:
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ТАЛУУД

Монгол Улсын Их хурал, ХНХЯ, БСШУСЯ, ЭМЯ, Орон нутгийн захиргаад, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэр бүл, хүүхэд, залууудын хөгжлийн газар, Иргэний боловсролын төв, Монголын эмэгтэйчүүдийн үндэсний сүлжээ

МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА

НҮБ-аас Мэдээлэл харилцааны багаараа дамжуулан ТХЗ-ын талаарх мэдлэг мэдээллийг түгээн сайжруулах болон агаарын бохирдолтой тэмцэх, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудлууд, жендэрийн эрх тэгш байдал, жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн хамгаалал, боловсрол, хариуцлагатай хэрэглээ, төрийн албаны шинэчлэл, залуучуудын бизнес эрхлэлт гэх мэт хөгжлийн олон асуудлаар нөлөөлөл сурталчилгааны ажлыг хийж байна.

НҮБ нь Монгол Улсын үндэсний хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран мэдээллийн агуулга контент боловсруулах, ард иргэдэд боловсрол мэдлэг олгох видео бичлэгүүдийг бэлтгэн гаргах, ТХЗ-ын талаар ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБ-ын тусгай элч зэрэг НҮБ-ын төлөөлөл оролцсон хэвлэл мэдээллийн хурал, ярилцлага, хэвлэлийн бага хурал зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд НҮБ нь нийгмийн мэдээллийн хэрэгсэл ашиглан ТХЗ-ын талаар олон нийтэд чиглэсэн нийгмийн мэдээллийн кампанит ажлыг зохион байгуулж видео, зурагт хуудас, хүүхэдэйн кино, нийтлэлүүдийг гаргаж ажиллаа. Түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 70 жилийн ой, Эрх чөлөө ба тэгш байдал сэдэвт кампанит ажлууд, Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн идэвхжил зэрэг олон арга хэмжээг зохион байгуулсан. Хүний эрхийн өдөр, Дэлхийн хүнсний өдөр, Дэлхийн чихрийн шижинтэй тэмцэх өдөр, Дэлхийн эрүүл мэндийн өдөр, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хүнд хэлбэрийг устгах өдөр, Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр, НҮБ-ын өдөр, ДОХ-той тэмцэх өдөр гэх зэрэг Дэлхийн болон НҮБ-ын тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлж тэдгээр өдрүүдэд зориулан гарсан гол уриа мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэж ирсэн. Түүнчлэн ТХЗ-ын асуудлаарх Зүүн хойд Азийн олон талууд оролцсон чуулган, Монгол Улсад явуулсан Шилжих хөдөлгөөний судалгааны үр дүнг танилцуулах уулзалт, Ундны ус, ариун цэврийн байгууламжийн асуудал эрхэлсэн Хүний эрхийн тусгай илтгэгчийн оролцсон хэвлэлийн бага хурал зэрэг Монгол Улсын Их хурал, Засгийн газар, НҮБ-ын төлөөлөл




©НҮБ-ын СЗАА

оролцсон олон арга хэмжээг нүүр хуудас/фэйсбүүк-ийн шууд бичлэгээр дамжуулан олон нийтэд хүргэсэн болно.

ТХЗ, хүний эрх, Монгол Улс болон НҮБ-ын хамтын ажиллагааны талаарх цуврал лекцийг НҮБ, их, дээд, дунд сургуулийн оюутан сурагчид, залуу удирдагчдад зориулан Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисстой хамтран зохион байгууллаа. НҮБ-ын Суурин зохицуулагчийн хийсэн лекцийн тэмдэглэлүүдийн бичлэгийг хийж, одоогоор вэбсайт дээр байрлуулах, нийгмийн хэвлэл мэдээллийн сувгууд дээр байрлуулахаар ажиллаж байна.

ТХЗ-ын асуудлаарх Зүүн хойд Азийн олон талууд оролцсон чуулган, Гамшгийн эрсдлийг бууруулах асуудлаарх Азийн сайд нарын бага хурал, ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлаарх НҮБ, АХБ-ын хамтарсан багийн уулзалт, Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд байгуулсан Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан Нэг цэгийн үйлчилгээний төвийн нээлт зэрэг бүсийн түвшний болон үндэсний хэмжээний томоохон арга хэмжээг зохион байгуулахад НҮБ-ын Мэдээлэл харилцааны багийнхан мэдээлэл, харилцааны мэргэжлийн туслалцаа үзүүлж ажиллаж байна.

Монгол дахь НҮБ-аас нь агаарын бохирдлын эсрэг хойшлуулшгүй арга хэмжээ авах талаар албан ёсны мэдэгдэл гаргасан. Энэхүү мэдэгдлийг Монгол Улс дахь НҮБ-ын албан ёсны нүүр хуудаст байршуулж, нийгмийн сүлжээний платформ дээр нийтэлсэн. Олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулахад чиглэсэн НҮБ-аас гаргасан мэдээллүүд, эрүүл мэндийг хамгаалах зөвлөгөө, өвлийн улирлын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаарх мэдээлэл нь нийгмийн сүлжээгээр дамжин хэдэн арван мянган хүнд хүрсэн байна.



НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улс дахь НҮБ-ын Баг (UNCT) нь эдийн засгийн цар хүрээгээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагааныхаа зардлыг бууруулах зорилгоор бизнесийн нийтлэг үйл ажиллагаагаа дэвшилтэт арга хэлбэрээр явуулах зорилт тавин ажиллаж байна. Үйл ажиллагааны удирдлагын баг (OMT) нь НҮБ-ын системийн байгууллагуудын үйл ажиллагааг хамтарсан хэлбэрээр явуулах, НҮБ-ын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх талаар чармайн ажиллаж байна. Худалдан авалтын бизнесийн үйл ажиллагааг хялбаршуулах, уялдуулан зохицуулах зорилгоор Үйл ажиллагааны удирдлагын баг нь нийтлэг үйлчилгээний Худалдан авалтын Ажлын хэсгийг байгуулсан. НҮБ-ын системийн байгууллагуудын идэвхтэй хамтын ажиллагаа, дэмжлэгт суурилан 2018 онд нийт 14 худалдан авалтыг хамтарсан санхүүжилтээр хийсэн бөгөөд урт хугацаатай нийтлэг үйлчилгээний гэрээ (LTA) боловсруулах, ногоон орчинг бүрдүүлэх, хог хаягдлын менежментийн үйл ажиллагаа, ажлын байрны орчныг тохижуулах зэрэг ажлыг хийлээ. Ингэснээр ажилтнуудын цаг, хүчийг илүү үр дүнтэй ашиглаж захиргааны зардлыг бууруулахад тустай болсон төдийгүй хязгаарлагдмал хүчин чадалтай байсан байгууллагууд худалдан авалтаа саадгүй хийх боломж бүрдсэн.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг байгууллагууд нь ажлын хэрэгцээний автомашинаа дундаа хамтран ашиглах төсөл үр дүнтэй хэрэгжиж, үйл ажиллагааны зардлыг бууруулахад сайнаар нөлөөлж байгаагийн зэрэгцээ ажилтнуудын цагийг хэмнэж байна. Энэ нь цаашид орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа уялдуулах, орон нутаг дахь төсөл хөтөлбөрийн удирдлага болон үр дүнгийн гүйцэтгэлийн үр ашгийг дээшлүүлэх, экологийн ул мөрийг арилгах, ажилтнууд болон тээврийн хэрэгслийн аюулгүй, баталгаатай байдлыг дээшлүүлэх, улмаар НҮБ-ын бизнесийн үйл ажиллагааны өртөг зардлын үр ашгийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулна. Төслүүдийн нийтлэг үйлчилгээний асуудал хариуцсан менежер томилогдож, ажлын хэрэгцээний автомашиныг дундаа ашиглах журам (SOPs) боловсруулах ажил хийгдэж байна.

ДЭМБ-аас бусад Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа НҮБ-ын системийн бүх байгууллагууд Монгол Улсын Засгийн газраас барьж өгсөн НҮБ-ын байранд байрлаж байна. Харин ДЭМБ нь ЭМЯ-нд байрлаж үйл

ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны удирдлагын багаас зохион байгуулж НҮБ-ын байрыг ногоон орчинтой болгох чиглэлээр нилээд хэдэн ажил зохион байгуулсны дотор өрөө, хонгил бүрт хог хаягдал ялган хаях савуудыг байрлуулж, ариун цэврийн өрөөнүүдийг мэдрэгчтэй LED гэрэлтүүлэгээр тоноглож, гаднах цэцэрлэгт хуванцарыг дахин боловсруулж хийсэн саравч сандал суурилуулж тохижуулах зэрэг ажлуудыг хийлээ.

НҮБ-ын Хөгжлийн сангийн Мөнгөн шилжүүлгийн нийтлэг журмын (UNDG HACT) хүрээнд - түншлэгч Засгийн газрын байгууллагууд болон төрийн бус байгууллагуудад (IP & RP) бэлэн мөнгө шилжүүлэх нийтлэг журмыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан зэрэг НҮБ-ын системийн байгууллагуудын баялаг туршлага, мэдлэгт түшиглэж НҮБ-ын үйл ажиллагаанд мөрдөж байна. Монгол Улсын төсвийн санхүүжилтийн удирдлага болон гарч болзошгүй эрсдэлд НҮБ-ын HACT-ийн Ажлын хэсгээс зохион байгуулж HACT-ийн макро түвшний үнэлгээ хийж ажиллаж байна. HACT макро түвшний үнэлгээний үр дүнг НҮБ-ын системийн байгууллагууд хамтаар хэлэлцэж эцэслэсэн бөгөөд Ажлын хэсгээс макро түвшинд гарч болзошгүй эрсдлийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, зөвшилцсөн. Тус ажлын хэсэг нь хөтөлбөрийн хэрэгжилтэд аудитын хяналт шалгалт хийх, гэнэтийн түүвэр шалгалт хийх, нийтлэг үйлчилгээний шинж байдал (HACT үйлчилгээг хамтран гэрээлэх, хамтарсан үнэлгээ хийх замаар), байгууллагуудын онцлогт нийцүүлсэн микро түвшний үнэлгээний тайланг ашиглах зэргийг сайжруулах талаар үргэлжлүүлэн ажиллаж байна. 2018 онд Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, БОАЖЯ, Онцгой байдлын ерөнхий газар, Анагаахын шинжлэх ухааны их сургууль, Улаанбаатар хотын Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Өмнөговь аймгийн ЗДТГ зэрэг хэд хэдэн Хэрэгжүүлэгч байгууллага (IP) дээр микро түвшний үнэлгээ хийсэн. НҮБ-ын HACT журмын хүрээнд хийсэн макро болон микро түвшний үнэлгээний тайлан, гэнэтийн шуурхай шалгалт зэргийг үндэслэн хөтөлбөр хэрэгжүүлэхэд тулгарч болзошгүй үйл ажиллагааны эрсдлийг цаг тухайд нь тодорхойлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаар гүйлгээний зардлыг бууруулж, мөнгөн шилжүүлгийг үр дүнтэй удирдах боломж нөхцөл бүрдэнэ.

ХАВСРАЛТ: НИЙТ ТӨСВИЙН ХҮРЭЭ													
Үр дүн	Байгууллага	НҮБ-ын ХТХ		Нийт шаардагдах			Нийт босгосон			Нэмж босгох	ЗАРЦУУЛАЛТ		
		АМЛАЛТ	Бүгд	Core	Non-Core	Бүгд	Core	Non-Core	2017		2018	Бүгд	
Үр дүн 1 Нийт шаардагдах: 32,294,368 ам.доллар	НИЙТ ДҮН	79,670,034	63,022,923	18,309,971	44,712,951	61,138,271	17,195,320	43,942,950	1,884,652	21,190,635	22,039,788	43,230,422	
	Үр дүн 1 Бүгд	34,199,242	32,294,368	6,502,593	25,791,775	31,717,487	6,137,593	25,579,894	576,881	10,554,464	11,590,581	22,145,045	
	НҮБ ХХ	20,000,000	10,921,093	2,173,187	8,747,906	10,699,322	2,088,187	8,611,135	221,771	3,886,805	2,879,921	6,766,726	
	НҮБ АУХБ	2,277,242	9,254,909		9,254,909	9,254,909		9,254,909	-	850,000	5,056,778	5,906,778	
	ХХААБ	3,700,000	5,661,757		5,661,757	5,661,757		5,661,757	-	4,352,692	1,601,235	5,953,927	
	ОУШХБ		2,320,238	1,875,000	445,238	2,320,238	1,875,000	445,238	-	400,224	691,090	1,091,314	
	НҮБ ХС	100,000	1,647,006	1,647,006		1,647,006	1,647,006		180,000	220,752	604,177	824,929	
	НҮБ БОХ	1,500,000	1,135,063		1,135,063	1,135,063		1,135,063	-	313,863	371,200	685,063	
	ОУХБ	750,000	667,400	667,400		617,400	617,400		50,000	434,962	181,428	616,390	
	НҮБ Нутагшилт	100,000	181,467		181,467	181,467		181,467	-	95,167	86,300	181,467	
Үр дүн 2 Нийт шаардагдах: 14,998,200 ам.доллар	ОУЦЭХБ	1,400,000	300,435		300,435	225,325		225,325	75,110	0	66,452	66,452	
	ДЭМБ	4,050,000											
	НҮБ БШУСБ	322,000	205,000	140,000	65,000	155,000	90,000	65,000	50,000		52,000	52,000	
	Үр дүн 2 Бүгд	37,855,792	14,998,200	8,380,024	6,618,176	13,934,421	7,721,985	6,212,436	1,063,779	6,123,160	6,358,828	12,481,988	
	ДЭМБ	7,192,565	4,571,431	3,745,199	826,232	4,571,431	3,745,199	826,232	0	2,918,600	1,628,599	4,547,199	
	НҮБ ХС	18,513,227	5,211,524	2,025,138	3,186,386	4,559,531	1,778,885	2,780,646	651,993	1,850,282	1,855,625	3,705,907	
	НҮБ ХАС	9,300,000	2,775,114	586,751	2,188,363	2,775,114	586,751	2,188,363		931,283	1,705,872	2,637,155	
	ОУЦЭХБ	1,700,000	1,297,444	1,297,444		1,175,658	1,175,658		121,786	6,376	748,421	754,797	
	ХХААБ		313,247	86,492	226,755	313,247	86,492	226,755	0	164,572	148,675	313,247	
	НҮБ БШУСБ	300,000	620,000	620,000	0	330,000	330,000	0	290,000	110,000	180,000	290,000	
Үр дүн 3 Нийт шаардагдах: 15,730,354 ам.доллар	НҮБ Нутагшилт	100,000	190,440		190,440	190,440		190,440		100,000	90,440	190,440	
	НҮБ ДОХ-ын сан									24,232	0	24,232	
	ОУХБ	750,000	19,000	19,000		19,000	19,000			17,815.00	1,196.00	19,011	
	Үр дүн 3 Бүгд	7,615,000	15,730,354	3,427,354	12,303,000	15,486,362	3,335,742	12,150,620	243,992	4,513,011	4,090,379	8,603,390	
	НҮБ ХАС	5,000,000	4,766,532	2,453,524	2,313,008	4,766,532	2,453,524	2,313,008	0	2,562,950.00	1,645,922.00	4,208,872	
	НҮБ ХХ	750,000	8,350,000	100,000	8,250,000	8,350,000	100,000	8,250,000	0	1,029,522.53	1,693,085.00	2,722,608	
	НҮБ ХС	450,000	1,000,000	600,000	400,000	756,008	508,388	247,620	243,992	333,701.00	418,605.00	752,306	
	ОУХБ	1,000,000	430,000	260,000	170,000	430,000	260,000	170,000	0	340,678.00	89,322.00	430,000	
	ОУШХБ		983,596	-	983,596	983,596	0	983,596	0	189,579.20	139,965.20	329,544	
	НҮБ Нутагшилт		148,320		148,320	148,320		148,320		48,320.00	100,000.00	148,320	
Босгосон: 15,486,362 ам.доллар	ДЭМБ	50,000	13,830	13,830		13,830	13,830			8,260.00	3,480.00	11,740	
	НҮБ БШУСБ	365,000	38,075		38,075	38,075		38,075.47					



UNITED NATIONS
MONGOLIA

